



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРӨӨС БҮХ НИЙТИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ
ОЛГОЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ҮР ДҮНД
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: БНА-2020/03/-ГА

БОЛОВСРОЛЫН САЛБАРТ МӨРДӨГДӨЖ БУЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ,
ХАРИЛЦАН УЯЛДАА ХАНГАЛТГҮЙ, ШАТ ШАТНЫ ХЯНАЛТЫН ҮР НӨЛӨӨ БАГА БАЙГАА
НЬ СУРГАЛТЫН ЧАНАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХЭД СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ БАЙНА.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер А.Цээням
Утас: 70442424 цахим хуудас: tseenyma@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Азбаяр
Утас: 99061429 цахим хуудас: azbayarb@audit.gov.mn
Аудитор Ж.Өсөхбаяр
Утас: 99890393 цахим хуудас: usukhbayari@audit.gov.mn
Аудитор П.Амаржаргал
Утас: 88106996 цахим хуудас: amarjargalp@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товъёг	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	5
БҮЛЭГ 1. ТӨРӨӨС ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО ОНОВЧТОЙ БАЙГАА ЭСЭХ	6
<i>А.1. Боловсролын салбарт мөрдөгдөж буй зарим эрхзүйн зохицуулалт хоорондын харилцан уялдаагүй, өнөөгийн нөхцөл байдалд нийцэж шинэчлэгдээгүй байна.....</i>	6
<i>А.2. Орон нутгийн түвшинд хүний нөөц, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг урьдчилан оновчтой тооцдоггүй, төсвийн болон хөрөнгө оруулалтын оновчгүй хуваарилалт хийж тэгш хүртээмжтэй орчин бүрдүүлээгүйгээс зарим сургуулийн багшийн ачаалал их мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдаагүй байна.....</i>	9
<i>А.3. Бүх нийтийн ерөнхий боловсролын үйл ажиллагааны санхүүжилтийг оновчтой хуваарилж, хяналтыг бүрэн хэрэгжүүлдээгүйгээс зардлын хэмнэлтийг төсвийн зохицуулалтаар бусад зардалд дахин хуваарилж зарцуулдаг жишиг тогтсон нь төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх заалтыг зөрчсөн байна.....</i>	22
БҮЛЭГ 2. Ерөнхий боловсрол олгох үйлчилгээний зорилго, зорилт хангагдаж байгаа эсэх	32
<i>Б.1. Ерөнхий боловсрол олгох үйлчилгээний үр дүнд салбарын яамнаас хийж буй чанарын үнэлгээг хязгаарлагдмал хүрээнд хийснээс сургалтын чанар бодитой үнэлэгдэхгүй, сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлийг тодорхойлохгүй байна.....</i>	32
<i>Б.2. Бүх нийтийн ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд тавих хөндлөнгийн болон дотоод хяналт шалгалтын бүрэн хэрэгжүүлдээгүй хяналт шалгалтын үр дүнг тооцож ажиллахгүй байна.....</i>	41
ДҮГНЭЛТ:	48
ЗӨВЛӨМЖ:	49
ҮАГ-ЫН ГАГ-Т ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:	51

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт
БШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БҮТ	Боловсролын үнэлгээний төв
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
НХХС	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
БСУГ	Боловсрол, соёл урлагийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
НТБ	Насан туршийн боловсрол
ДЗОНХХ	Дэлхийн зөн, олон нийтийн хөгжлийн хөтөлбөр
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ААН	Аж ахуйн нэгж
ОУБ	Олон улсын байгууллага
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Бодлогын баримт бичгийн харилцан уялдаа	10
Хүснэгт 2	ЕБС-ийн бүлгийн тоо	12
Хүснэгт 3	Аймгийн төвийн сургуулиудын анги дүүргэлт	12
Хүснэгт 4	Бага сургуулиудын үндсэн үзүүлэлт	14
Хүснэгт 5	Бага сургууль болон сумын сургуулийн бага ангийн анги дүүргэлт	15
Хүснэгт 6	2016 оноос хойш УТХО-аар баригдаж буй сургууль	15
Хүснэгт 7	2016 оноос хойш УТХО-аар их засвар хийгдсэн сургууль /сая.төг/	17
Хүснэгт 8	Ерөнхий боловсролын сургуулийн гадаад орчны аюулгүй байдлын үнэлгээ	18
Хүснэгт 9	Ерөнхий боловсролын сургуулийн дотоод орчны аюулгүй байдлын үнэлгээ	18
Хүснэгт 10	ЕБС-иудад ажиллаж буй багшийн судалгаа	20
Хүснэгт 11	ЕБС-иудад ажиллаж буй мэргэжлийн бус багшийн судалгаа	20
Хүснэгт 12	ЕБС-д батлагдсан зардлын үзүүлэлт	24
Хүснэгт 13	Төсвийн төсөлд өгсөн хувьсах зардлын цалингийн тооцоолол	24
Хүснэгт 14	2017-2019 онуудын батлагдсан төсвийг зардлын төрлөөр харьцуулав	25
Хүснэгт 15	2017-2019 онуудын батлагдсан төсөв сургуулийн төрлөөр.	26
Хүснэгт 16	Дотуур байрны хүүхдийн хоолны зардлын төлөвлөгөө гүйцэтгэл	28
Хүснэгт 17	Ном, хэвлэлийн зардлыг төсвийн төсөл, батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэл	29
Хүснэгт 18	Батлагдсан төсөвт орсон төлөвлөлт /мянган төгрөгөөр/	30
Хүснэгт 19	Батлагдсан төсвийн гүйцэтгэл /сангийн яамны тайлангаар/	30
Хүснэгт 20	Багш нарын түвшин	31
Хүснэгт 21	ЕБС-уудад хэрэгжсэн төсөл хөтөлбөр	32
Хүснэгт 22	Бага боловсролын улсын шалгалтын нэгтгэл	35
Хүснэгт 23	Ахлах ангийн улсын шалгалтын нэгтгэл	35
Хүснэгт 24	ЭЕШ-ын дүнгийн нэгтгэл	36
Хүснэгт 25	2017 оны чанарын үнэлгээний судалгааны нэгтгэл	38
Хүснэгт 26	2018 оны чанарын үнэлгээний судалгааны нэгтгэл	39
Хүснэгт 27	2019 оны чанарын үнэлгээний судалгааны нэгтгэл	39
Хүснэгт 28	2019 оны бүх 9-р ангийн чанарын үнэлгээний судалгааны дүн	40
Хүснэгт 29	Чанарын үнэлгээний дүнгийн нэгтгэл	40
Хүснэгт 30	БС-уудад хэрэгжүүлсэн тэтгэлэгт төсөл, хөтөлбөр	42

Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Хүүхдийн цүнхний жингийн талаар өгсөн зөвлөмж	37

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	2016-2019 онуудын цалингийн хувьсах зардал болон тооцоолсон цалинг харьцуулав. /төсвийн төсөл/	8
Дүрслэл 2	Багшийн тоо /төгссөн сургуулиар/	20
Дүрслэл 3	Батлагдсан төсөв /зардлын төрлөөр/	25
Дүрслэл 4	Батлагдсан төсвийн бүтэц	25
Дүрслэл 5	Аймгийн төвийн ЕБС-ийн 2017-2019 онуудын нэг хүүхдэд хуваарилагдсан нийт зардлын харьцуулалт	26
Дүрслэл 6	2017 онд нэг багшид ногдох хүүхдийн тоо болон нэг хүүхдэд хуваарилагдсан нийт зардал	26
Дүрслэл 7	2019 онд нэг багшид ногдох хүүхдийн тоо болон нэг хүүхдэд хуваарилагдсан нийт зардал	27
Дүрслэл 8	Багийн сургуулиудын нэг хүүхдэд ногдох хувьсах зардал /2017-2019 он/	27
Дүрслэл 9	Бусад хувьсах зардалд хичээл практик болон, ном хэвлэлийн зардлын эзлэх хувийн жин	29
Дүрслэл 10	2017-2019 онуудын Үдийн цай хөтөлбөр	32
Дүрслэл 11	Багшийн ажлыг цагийн норматив	34
Дүрслэл 12	Санал асуулгын дүн- Сургуулийн хэмжээнд сургалтын чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, үнэлэх ажил хийгддэг үү?	41
Дүрслэл 13	Санал асуулгын дүн- Сургуулийн сурагчдын сурлагын чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийг нэрлэнэ үү.	41
Дүрслэл 14	МХГ-аас 2016-2019 онд хийгдсэн хяналт шалгалт	45

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны тоо
Хавсралт 1	Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын орчны судалгаа /2019-2020 оны хичээлийн жилийн байдлаар/	1
Хавсралт 2	Ерөнхий боловсролын сургуулийн орон нутгийн хэрэгцээ шаардлага, хамран сургалтын судалгаа	3
Хавсралт 3	Багш боловсон хүчний судалгаа	4
Хавсралт 4	Төрийн өмчийн сургуулиудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн судалгаа	3

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх Аудитын зорилт	Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалын дагуу “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”-д Төрийн аудитын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийв. “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”д улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: ➤ Ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн нөхцөл хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх; ➤ Ерөнхий боловсрол олгох үйлчилгээний зорилго, зорилт хангагдаж байгаа эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг аймгийн ИТХ, ЗДТГ, БСУГ, МХГ, төрийн болон хувийн өмчийн сургуулиудын 2016-2018 оны үйл ажиллагааг /сүүлийн 3 хичээлийн жил/ хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын хязгаарлалт Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	 Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүй, Монгол Улсын стандарт-Төрийн аудит MNS6817:2020-ыг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, боловсролын салбарын статистик мэдээ, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материал, үндсэн үзүүлэлтийн судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, аудитын менежер А.Цээням аудитын стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналт тавьж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор П.Амаржаргал, Ж.Өсөхбаяр, Б.Нарангэрэл, хөндлөнгийн шинжээчээр аймгийн БСУГ-ын Сургалт, арга зүйн хэлтсийн дарга Б.Жамбалдорж, мэргэжилтэн Д.Цэцэнхүү, С.Гандалай, МХГ-ын боловсролын хяналтын улсын байцаагч нар хөтөлбөр, хуваарийн дагуу гүйцэтгэв.
Хүндрэл бэрхшээл	Аудитын дэд төлөвлөгөөг 2020.09.02-ний өдөр батлуулж, талбарын ажлыг 2020.09.07-ны өдрөөс 2020.10.09-ний өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайланг 2020.10.24-нөөс холбогдох үе шатны хяналтаар хянуулан Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж, ҮАГ-ын ГАГ, аймгийн ИТХ, Засаг дарга, БСУГ, МХГ-т Ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлэв. 1. Аймгийн ЗДТГ-ын СТСХ нь төсвийн төсөл болон төсвийн зохицуулалттай холбоотой шаардлагатай материалыг цаг тухай бүрд нь гаргаж өгөөгүй. 2. Аудитын цар хүрээ их, цаг хугацаа хязгаарлагдмал мөн тусгай мэргэжлийн шинжээч шаардлагатай байгаагаас шалгагдагч байгууллагын мэргэжилтнүүдийг татан оролцуулсан. 3. Зарим сургуулиудын аудитад шаардлагатай материалууд архивлагдаагүйгээс хангалттай нотлох баримт цуглуулахад бэрхшээлтэй байсан.

БҮЛЭГ 1. БОЛОВСРОЛЫН САЛБАРТ МӨРДӨГДӨЖ БУЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ХАРИЛЦАН УЯЛДАА ХАНГАЛТГҮЙГЭЭС САНХҮҮГИЙН БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХУВААРИЛАЛТЫН ҮР НӨЛӨӨ БҮРЭН ГАРАХГҮЙ БАЙНА.

А.1. Боловсролын салбарт мөрдөгдөж буй зарим эрхзүйн зохицуулалт хоорондын харилцан уялдаагүй, өнөөгийн нөхцөл байдалд нийцэж шинэчлэгдээгүй байна.

А.1.1.1. Боловсролын тухай хуулийг дагаж гарах 22 төрлийн дүрэм, журам батлагдан гарахаас 18 төрлийн дүрэм журам батлагдан гарч мөрдөгдөж байгаа бөгөөд дараах хууль журмыг баталж, нийтэд мэдээлэгдээгүй байна. Үүнд:

- *Боловсролын тухай хуулийн 25.6-д “Энэ хуулийн 25.2-т заасныг хэрэгжүүлэхтэй холбоотой дүгнэлт гаргах аргачлал, журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”.*
- *Боловсролын тухай хуулийн 28-д Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 28.1.23-д “төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны хүүхдийн хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэх журам батлах”*
- *Боловсролын тухай хуулийн 41.2-д “Төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчныг сайжруулах, тэдгээрийг багшлах боловсон хүчнээр хангахад Засгийн газар тогтоосон журмын дагуу дэмжлэг, туслалцаа үзүүлнэ”.*
- *Боловсролын тухай хуулийн 41.4-д “Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд монгол хэл, түүх, ёс заншил, соёлын чиглэлээр суурь чадамж эзэмшүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлж болох бөгөөд дэмжлэг үзүүлэх нөхцөл, шаардлага, хэмжээг Засгийн газрын баталсан журмаар зохицуулна”*

Иймд дээрх хууль тогтоомжийг баталж нийтэд мэдээлэх зөвлөмжийг Боловсролын яаманд хүргүүлэх саналыг ҮАГ-ын ГАГ-ын аудитын багт хүргүүлэв.

Аудитад хамрагдсан 2016-2019 онуудад гүнзгийрүүлсэн сургалтыг аймгийн төвийн “Номундалай”, “Номгон”, “Эрдэнэмандал”, “Эрдэм” сургуулиуд зохион байгуулж байгаа бөгөөд дээрх сургуулиудын сургалт зохион байгуулж буй журам, төлбөрийн хэмжээг хэрхэн тогтоосныг авч үзэхэд дараах зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор сумын “Номундалай” цогцолбор сургууль, “Эрдэнэмандал”, “Эрдэм” сургуулиуд нь “Гүнзгийрүүлсэн сургалт зохион байгуулах журам”-ыг сургуулийн зөвлөлөөр батлуулаагүй, захирлын тушаалаар баталсан нь Боловсролын тухай хуулийн 35.4.8¹ дэх заалтыг зөрчсөн байна

Иймд “Гүнзгийрүүлсэн сургалт зохион байгуулах журам”-ыг хуульд заасны дагуу сургуулийн зөвлөлөөр тогтоолгон зөрчлийг арилгах албан шаардлагыг дээрх сургуулиудын удирдлагад хүргүүлэв.

А.1.1.2. Салбарын яам захиргааны хэм хэмжээний актад ямар санал авсан эсэхийг орон нутгийн түвшинд тодорхойлох боломжгүй байна.

А.1.1.3. Аудитын явцад батлагдсан журмын хувьд өнөөгийн нөхцөл шаардлагыг хангасан, хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээл тулгарч байгаа эсэх талаар сургуулиудын

¹ сургалтын төлбөрийн хэмжээг зохих журмын дагуу тогтоох.

захирал, багш, менежерүүдтэй санал бодол солилцоход ямар нэгэн санал гаргаагүй болно.

Аудитаар боловсролын салбарын зохицуулагдаж байгаа зарим хууль, журам нь харилцан уялдаагүй байна. Тухайлбал:

- *Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай* хуулийн 6.5-д “Сургуульд хоол зүйч, мэргэжлийн тогооч, туслах тогооч ажиллах бөгөөд суралцагчийн тооноос хамаарч бэлтгэгч, угаагч, үйлчлэгч ажиллана” гэж заасан байхад Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар “Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив”-д хоол зүйчийн орон тоо байхгүй бөгөөд тус орон тоог жишиг нормативд шинээр нэмж өөрчлөлт оруулаагүй байгаа нь хууль хэрэгжих боломжийг бүрдүүлж өгөөгүй байна.

Мөн боловсролын салбарт мөрдөгдөж буй зарим журам нь өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна. Тухайлбал:

- Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3-д “Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн, аймгийн төвөөс бусад сум, тосгон, багийн сургуульд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно” гэж заасан байхад хувьсах зардлын норматив нь 2016 онд батлагдсан журмыг баримтлан ажиллаж төлөвлөлтийг хийж байна. **Жишээлбэл:** Хувьсах зардлын нормативыг шинэчлэн тогтоогүйгээс ЕБС-ийн төсвийн дийлэнх хувийг бүрдүүлж байгаа цалингийн зардалд жилд 2127.1-3943.8 сая төгрөгийн зөрүү үүсэж норматив зөрчигдөх үр дагавар гарч байна.



Иймд дээрх хуулийн зөрчилдөөнтэй болон шинэчлэх шаардлагатай заалтыг өөрчлөх саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх саналыг ҮАГ-ын ГАГ-т хүргүүлэв.

А.1.2.1. БШУЯ-ны сайдын 2014 оны А/240 тоот тушаалаар батлагдсан “Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр”, БСШУЯ-ны сайдын 2016 оны А/277 тоот тушаалаар батлагдсан “Бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөр”, 2016 оны А/302 тоот тушаалаар батлагдсан “Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр”-ийг ЕБС-ууд сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байжээ.

Дээрх хөтөлбөрийг сайжруулах хэрэгцээ шаардлага байгааг “Тогтвортой хөгжил-Ерөнхий боловсрол” багш нарын улсын хоёрдугаар зөвлөгөөн, “Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр” үндэсний хэлэлцүүлэг, “Монголын багш нарын VII их хурал”-аас гарсан санал, зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн БСШУС-ын сайдын 2019 А/492 дугаар тушаалаар “Бага, суурь, бүрэн дунд боловсролын сайжруулсан

хөтөлбөр"-ийг шинэчлэн баталж ЕБС-ийн сургалтын үйл ажиллагаанд мөрдүүлсэн байна.

Аудитаар аймгийн БСУГ-ын мэргэжилтнүүдээс аудитад хамрагдсан 2016-2019 онд хэрэгжсэн сургалтын цөм хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, давуу болон сул талыг тодорхойлуулахад дараах дүгнэлтийг өгч байна.

Сургалтын хөтөлбөрийн шинжилгээ хийх хүрээнд багш нар цөм болон сайжруулсан хөтөлбөрийн зорилго, зорилтыг хангах, шийдэл шинэчлэлийн үзэл санааг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлсэн байдал, сургалтын агуулгыг бүрэн дүүрэн оруулж чадсан эсэх, хөтөлбөр сургалтыг чанартай явуулах удирдамж нь болж чадах эсэхийг тогтоох нийтлэг сайн ба дутагдалтай талыг илрүүлж явуулахыг зорьжээ.

Сургалтын цөм болон сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулж хэрэглэснээр багш нарт гарсан ахиц, дэвшил:

- Сургуулиуд багш нартаа хэрэглэгдэх-чанартай хөтөлбөр боловсруулах арга зүйг ойртуулж ижилсгэх, хөтөлбөрийг ижил загвартай болгох шаардлага тавьсан;
- Боловсруулсан хөтөлбөрийг жил бүр шинэчилдэг бус, харин сайжруулж дахин хэрэглэхийг багш нарт зөвшөөрсөн;
- Багш нар хичээл, сургалтыг явуулахдаа заах гэсэн утгаар хандахаа больж сургалтын зорилтыг сурагчийн бие даасан ба хамтын үйл, үйл ажиллагаагаар хангах, тэднээр мэдлэг бүтээлгэхээр явуулахыг зорих болсонтой холбогдож ээлжит хичээлийн явц дахь багш сурагчийн үйл, үйл ажиллагааг бодож төлөвлөдөг болсноор ихээхэн ахиц гарсан;
- Сургалтын хөтөлбөрт нийцүүлж хичээлд ашиглах хэрэглэгдэхүүн, ажлын хуудас, туршилтыг бэлтгэж төлөвлөн сургалтаа явуулахад ахиц гарсан, энэ хүрээнд багш бүр хичээлд хэрэглэх цахим хэрэглэгдэхүүн, цахим танилцуулга бэлтгэн ашигладаг болсон.

Цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд учирсан бэрхшээл, хөтөлбөрийн боловсруулалтад байсан нийтлэг дутагдал нь:

- Сургалтын хөтөлбөрийн “сурах арга барил, эзэмших чадвар”-ыг багш нар “Сургалт явуулах арга зүй”, “Хичээл дээр сурагчдын хийх үйл ажиллагааны бүтвэр буюу үйл ажиллагааны чиглүүлэг”, “Хичээлийн бүтвэр хэсэг”, “Сурагчдын эзэмших арга, чадвар” гэж өөр өөрөөр ойлгож хандаж байсан.

Энэ нь багшийг давтан сургах, ойлголт ухаарлыг нэгтгэх үйл ажиллагаатай холбогдох хэдий ч хэрэгжилтэд суралцах цаг хугацаа хэт богино байсантай холбоотой байсан гэж үзэх үндэстэй.

Хэдийгээр боловсролын сургалтын цөм хөтөлбөр мөрдөгдөхгүй болсон ч одоогийн сайжруулсан хөтөлбөрт туссан дийлэнх шийдлийн эх үндэс нь болсон, хэрэгжүүлэхэд нь багш нарт туслах олон удаагийн сургалт арга хэмжээ явуулсан боловч багш нарын төдийгүй сургуулийн удирдлагын мэдлэг, чадвар, хандлага, сэтгэлгээ, хариуцлагын байдал, хэрэгжилтийн менежмент, хяналт ба зөвлөн туслах үйл ажиллагаатай холбоотойгоор сургуулиудад хөтөлбөрийн хэрэгжилт харилцан адилгүй байна.

A.1.2.2. Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024/, 2016 оны 19 дүгээр тогтоолоор

баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” гэсэн бодлогын баримт бичгүүдийг аудитад хамрагдсан онуудад мөрдөж байсан байна.

Сургалтын хөтөлбөр нь тус бодлогын баримт бичгүүдтэй харилцан уялдаатай байгаа эсэх талаар агуулгын дүн шинжилгээ хийж үзэхэд бодлогын баримт бичгүүд харилцан уялдаатай байгаа ба сургалтын хөтөлбөрт хийсэн сайжруулалт бодлогын баримт бичгийн хүрээнд нийцүүлэн гаргасан байна.

Хүснэгт №01. Бодлогын баримт бичгийн харилцан уялдаа

МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030	ТӨРӨӨС БОЛОВСРОЛЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО /2014-2024 он/	Өнөөгийн нөхцөл байдал
2016-2020 онд Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд /PISA/ хамрагдах бэлтгэлийг хангаж, нийт ерөнхий боловсролын сургуулийг хоёроос ихгүй ээлжээр хичээллэх боломжийг бүрдүүлэх, уламжлалт нүүдлийн ахуйд зохицсон боловсрол олгох хөтөлбөр боловсруулж, нэвтрүүлэх. Бүрэн дунд боловсрол эзэмшсэн хүүхэд бүр мэргэжлийн чиг баримжаатай болсон байх.	-3.5.Бүрэн дунд боловсролыг сонголттой, уян хатан хөтөлбөрөөр мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах чадвар бүхий, ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь баримжаа олгох үе хэмээн хөгжүүлнэ.	-ЕБС-ийн сургуулийг хоёроос ихгүй ээлжээр хичээллэх боломжийг бүрдүүлэх бодлогын хүрээнд шинээр сургууль барих өргөтгөх бодлогыг баримталж ажиллаж байна. Тухайлбал: Баянхонгор аймаг 9 сургуулийн барилга шинээр барих шийдвэр гаргаж хэрэгжүүлж байна.
	-7.10.Ерөнхий боловсролын сургууль нэг ээлжээр хичээллэх боломж бүрдсэн байна.	-ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.10 “Сургалтын стандарт, хөтөлбөр, сурах бичгийн агуулга, чанарыг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, өөрийн орны түүх, соёл, өв уламжлалд тулгуурлан шинэчилнэ” гэсэн заалтын хүрээнд 2019-2020 оны хичээлийн жилд сайжруулсан хөтөлбөрийг баталсан ба тус хөтөлбөрт ахлах ангиас эхлэн хичээл сонголт хийдэг болсон.
Суурь болон мэргэжлийн боловсролд хамрагдалтын түвшнийг 100 хувьд хүргэж, насан туршийн боловсролын тогтолцоог бүрдүүлнэ.	2.1.8.иргэдийн насан туршид суралцах хэрэгцээ, суралцагчийн сонирхол, авьяас, чадвар, хөгжлийн онцлогт нийцсэн, тэдэнд тэгш боломж олгосон, олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй байх;	- Баянхонгор аймагт ЕБС-д хамрагдалт 2019 оны байдлаар 81.9 хувь байна. - Баянхонгор аймагт ЕБС-д хамрагдалт 2019 оны байдлаар 572 иргэн дүйцсэн хөтөлбөрт хамрагдсан байна.
	7.11.Боловсролын удирдлага, мэдээллийн нэгдсэн системийг 2016-2017 оны хичээлийн жилээс үндэсний хэмжээнд бүрэн нэвтрүүлсэн байна.	Боловсролын статистик мэдээ, сурагч, багш, ажилтнуудын мэдээлэл, сурагчийн дүн цахим системд шилжсэн байна.

А.2. Орон нутгийн түвшинд хүний нөөц, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг урьдчилан тооцдоггүй, төсвийн болон хөрөнгө оруулалтын зөв хуваарилалт хийж тэгш хүртээмжтэй орчин бүрдүүлээгүйгээс зарим сургуулийн багшийн ачаалал их, мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдаагүй байна.

А.2.1.1. Аймгийн ИТХ-ын 2018.11.29-ний хуралдаанаар “Боловсролын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 14/01 тоот тогтоол гаргаж аймгийн Засаг даргад боловсролын салбарын урт хугацааны бодлогын баримт бичгийг төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллага, иргэдийн оролцоотойгоор боловсруулж, аймгийн ИТХ-ын хуралдаанаар батлуулах үүрэг өгч ажилласан байна.

Энэхүү үүргийн дагуу “Баянхонгор аймгийн боловсролын салбарыг 2020-2030 онд хөгжүүлэх дунд хугацааны бодлогын баримт бичиг”-ийг аймгийн ИТХ-ын хуралдааны 2019.11.29-ний өдрийн 18/13 тоот тогтоолоор батлуулан ажиллажээ.

Уг бодлогын баримт бичигт дараах 9 үндсэн зорилтыг дэвшүүлсэн байна.

1. Монгол Улсын боловсролын мастер төлөвлөгөөнд дэвшүүлсэн түвшинд хүргэх орон нутгийн боловсролын тогтолцоо болон сургалтын байгууллагын хэв шинжийг боловсронгуй болгох.
2. Суралцагсдад чадварт суурилсан мэдлэг эзэмших сургалтын арга технологийг нэвтрүүлж хувь хүний хөгжлийг хангах гол хөшүүрэг болгоно.
3. Бүх шатны боловсролын байгууллагын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, материаллаг орчныг сайжруулан орчин үеийн шаардлагад нийцэхүйц сургалтын эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх
4. Орчин үеийн менежментийн тогтолцоог нэвтрүүлэх
5. Боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар үр ашгийг дээшлүүлэхийн тулд салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлнэ.
6. Бүх нийтийн тогтвортой хөгжлийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох
7. Нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх
8. Гадаад дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх
9. “Боловсрол хотхон”-ыг байгуулах

Аудитын илрүүлэлт:

Гэвч дээрх бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээ, төсөв санхүүгийн тооцооллыг хийж төлөвлөгөө гаргаагүй байгаа нь бодлогын баримт бичиг хэзээнээс хэрхэн хэрэгжих эсэх нь тодорхойгүй байна.

Иймд Баянхонгор аймгийн боловсролын салбарыг 2020-2030 онд хөгжүүлэх дунд хугацааны бодлогын баримт бичиг”-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөц, төсөв санхүүгийн тооцоо, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, боловсролын салбарт мөрдүүлж биелэлтийг гарган аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Аудитад хамрагдаж буй 2016, 2017 онд аймгийн ИТХ нь Боловсролын тухай хуулийн 29.1.1, 29.1.2²-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Сайн багш”, “Хос бичигтэн”, “Робокон - Баянхонгор” дэд хөтөлбөрүүдийг баталсан байна.

Баянхонгор аймгийн боловсролын салбарыг 2020-2030 онд хөгжүүлэх дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хагас бүтэн жилээр гаргаж ажиллах үүргийг аймгийн Засаг даргад үүрэг болгосон бөгөөд 2020 оны эхний хагас жилийн биелэлтийг тооцож ИТХ-д тайлагнаагүй байна.

Дээрх байдлаас харахад аймгийн ИТХ нь төрийн өмчийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө баталсан боловч биелэлтэд хяналт тавих үүргээ хэрэгжүүлээгүй байгаа тул тогтоолын хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, хуулиар тогтоосон үүргээ хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн ИТХ-ын даргад хүргүүлэв.

² 29.1.1. боловсролын асуудлаар тухайн шатны ба доод шатны Засаг даргын тайлан хэлэлцэж, чиглэл өгөх;
29.1.2. орон нутгийн өмчийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө батлах, биелэлтэд хяналт тавих;

A.2.1.2. Аймгийн ЕБС-ууд 2016-2017 оны хичээлийн жилд 603 бүлэгт 15713 сурагч, 2017-2018 онд 604 бүлэгт 16050 сурагч, 2018-2019 онд 611 бүлэгт 16222 сурагч хичээллэсэн байна.

Аймаг, сумдын бүлгийн тоог БСШУ-ны сайд, НХХС, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 307/91/237 тоот тушаалаар баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох” журмын 1.4³-т анги дүүргэлтийг тогтоосонтой харьцуулан үзэхэд зарим сургууль анги бүлгээс хамаарч 2016-2017 оны хичээлийн жилд 13 бүлэг илүү, 7 бүлэг дутуу, 2017-2018 онд 9 бүлэг илүү, 11 бүлэг дутуу, 2018-2019 онд 8 бүлэг дутуу, 8 бүлэг илүү тус тус үүсгэсэн байна.

Хүснэгт №02. ЕБС-ийн бүлгийн тоо

№	Сумдын нэрс	2016-2017				2017-2018				2018-2019			
		Бүлгийн тоо	Байвал зохих бүлэг	Зөрүү		Бүлгийн тоо	Байвал зохих бүлэг	Зөрүү		Бүлгийн тоо	Байвал зохих бүлэг	Зөрүү	
				Илүү	Дутуу			Илүү	Дутуу			Илүү	Дутуу
	Аймгийн ЕБС-ийн дүн	260	266	0	6	259	269	0	10	260	268	0	8
	Сумын ЕБС-ийн дүн	329	317	13	1	331	323	9	1	332	324	8	0
	Багийн сургуулийн дүн	14	14	0	0	14	14	0	0	13	13	0	0
	Хувийн сургуулийн дүн	0	0	0	0	0	0	0	0	6	6	0	0
	НИЙТ ДҮН	603	597	13	7	604	606	9	11	611	611	8	8

Мөн аймгийн төвийн зарим сургуульд зайлшгүй бүлэг нэмж зохион байгуулах шаардлага үүссэн байхад анги дүүргэлтийг зохих түвшнээс илүү хүүхэдтэй хичээллүүлсэн байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:			
Сургуулийн нэр	2016-2017	2017-2018	2018-2019
“Баян-Ойт” бага сургууль	3 бүлэг /1,2,3 анги/	3 бүлэг /1,2,4-р анги/	2 бүлэг /2,5-р анги/
“Номундалай” ахлах сургууль	2 бүлэг /2,3-р анги/	3 бүлэг /1,3,4-р анги/	2 бүлэг /1,5-р анги/
“Соого сейко” ахлах сургууль	2 бүлэг /1,2-р анги/	3 бүлэг /1,2,3-р анги/	2 бүлэг /1,2,3,4-р анги/
“Эрдэм” ахлах сургууль	1 бүлэг /2-р анги/	2 бүлэг /1,2-р анги/	2 бүлэг /2,4-р анги/

Аудитаар анги дүүргэлтийг бүлэг тус бүрээр нь авч шинжилгээ хийхэд аймгийн төвийн сургуулиудын зарим бүлэг нь зохих түвшнээс их буюу 35-аас дээш 51 хүртэл хэтэрсэн анги дүүргэлттэй байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №03. Аймгийн төвийн сургуулиудын анги дүүргэлт

№	Сургуулийн нэр	он	Нийт хүүхдийн тоо	Үүнээс: сумдын хүүхдийн тоо	Дундаж бүлэг дүүргэлт	Хамгийн их бүлэг дүүргэлт
1	“Баян-Ойт” бага сургууль	2016-2017	502	2	39	51
		2017-2018	568	6	41	49
		2018-2019	544	7	39	49
2	“Номун далай” ахлах сургууль	2016-2017	2367	480	33	45
		2017-2018	2328	418	32	44
		2018-2019	2373	393	32	46

³ Анги дүүргэлтийг бага ангид 30-35 /багийн салбар бүлэгт 20-оос доошгүй/ дунд, ахлах ангид 32-35, ахлах ангийн мэргэжлийн болон сонгон судлах хичээлийн бүлэг дүүргэлтийг 25-30, харах, сонсох эрхтний хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн бүлэгт 8-12, оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн бүлэгт 10-15 хүүхэдтэй байхаар зохион байгуулна

3	“Номгон” сургууль	ахлах	2016-2017	2118	126	31	39
			2017-2018	2160	62	32	43
			2018-2019	2208	234	33	49
4	“Эрдэм” сургууль	ахлах	2016-2017	1380	30	29	40
			2017-2018	1409	53	30	45
			2018-2019	1359	61	30	45
5	“Эрдэнэмандал” ахлах сургууль	ахлах	2016-2017	1199	102	27	38
			2017-2018	1088	91	27	37
			2018-2019	1168	74	29	37
6	“Соого сейко” ахлах сургууль	ахлах	2016-2017	717	73	30	44
			2017-2018	658	68	30	45
			2018-2019	733	58	31	43

Дээрх хүснэгтээс харахад анги дүүргэлт “Баян-Ойт” бага сургуульд дундаж анги дүүргэлт зохих түвшнээс хэт өндөр байгаа бөгөөд бусад сургуулиудын дундаж зохих түвшинд байгаа хэдий ч бага бүлгийн анги дүүргэлт хэт их ачаалалтай байгаа нь БСШУ-ны сайд, НХХ-ийн сайд, Сангийн сайдын 2007 оны 307/91/237 тоот хамтарсан тушаалаар баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам”-ын 1.4-т заасан анги дүүргэлтийн зохих түвшнийг алдагдуулж **хүүхдийн сурах эрхийг** зөрчиж байна. /Аймгийн төвийн сургуулиудад суралцаж байгаа сумдын хүүхдийн судалгааг хавсралт № 05-д харуулав/

Харин дараах сургуулиуд зарим бүлгийн зохион байгуулалтыг дундаж түвшинд барих бололцоотой байхад зөв зохион байгуулаагүйгээс бүлэг дүүргэлт хэтэрсэн байна.

Аудитын илрүүлэлт:

№	Сургуулийн нэр	Хичээлийн жил	Анги бүлэг	Дундаж бүлэг дүүргэлт	Хамгийн өндөр бүлэг дүүргэлт	Хамгийн бага бүлэг дүүргэлт
1	“Номундалай” ахлах сургууль	2016-2017	1-р анги	34	43	28
		2018-2019	2-р анги	31	41	17
2	“Номгон” ахлах сургууль	2016-2017	3-р анги	35	39	29
		2017-2018	4-р анги	33	41	27
3	“Эрдэнэмандал” ахлах сургууль	2016-2017	2-р анги	32	36	28

Харин сумдын сургуулиудын анги дүүргэлт 2016-2019 онуудад дунджаар нэг ангид 26-27 хүүхэдтэй байхад Баян-Овоо сум, Шаргалжуут тосгоны ЕБС нь дунджаар 20-с бага хүүхдийн анги дүүргэлттэй байна.

Сумдын сургуулиудын анги дүүргэлтийн дундаж 30-аас бага байгаа бөгөөд зарим сумд тухай жилдээ нэгтгэх боломжтой бүлгийг 2 хувааж нэмж бүлэг үүсгэснээр төсөвт хамгийн багадаа 2016-2017 оны хичээлийн жилд 40,9 сая, 2017-2018 оны хичээлийн жилд 38,0 сая, 2018-2019 оны хичээлийн жилд 38,7 сая төгрөгийн нийт аудитад хамрагдсан 2016-2019 онуудад 117,6 сая төгрөгийн төсвийн хөрөнгөд хэмнэлт гарах боломжийг алдсан /хамгийн бага цалинтай багшийн цалингийн сүлжээгээр тооцоход/ зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

• 2016-2017 оны хичээлийн жилд Баянговь сумын дунд сургууль 3-р ангийн бүлгүүд, Баянлиг сумын дунд сургууль 4,5-р ангийн бүлгүүдийг, Баянцагаан сумын дунд сургууль 9-р ангийн бүлгүүдийг, Галуут сумын бүрэн дунд сургууль 1,2,4,7-р ангийн бүлгүүд, “Эрдэм” ахлах сургууль 8-р анги, Эрдэнэцогт сумын бүрэн дунд сургууль 5,6,7,11-р ангийн бүлгүүдийг,

• 2017-2018 оны хичээлийн жилд Баянлиг сумын бүрэн дунд сургууль 4,5,6-р ангийн бүлгүүдийг, Баянцагаан сумын бүрэн дунд сургууль 1,10-р ангийн бүлгүүдийг, Галуут сумын бүрэн дунд сургуулиуд 1,2,6-р ангиуд, “Эрдэм” ахлах сургууль 9-р ангийн бүлгүүдийг,

• 2018-2019 оны хичээлийн жилд Баян-Өндөр сумын дунд сургууль 6-р анги, Баянлиг сумын сургууль 7-р анги, Баянцагаан сумын сургууль 2,11-р ангийн бүлгүүд, Бууцагаан сумын ахлах сургууль 2-р анги, Гурванбулаг сумын сургууль 3,8-р ангиуд, Жаргалант сумын сургууль 7-р ангийн бүлгүүдийг нэгтгэх боломжтой байсан байна.

Үүнээс үзэхэд аймгийн БСУГ нь анги дүүргэлтийг нэгдсэн зохион байгуулалт удирдлагаар хангаж ажиллаагүй байгаа тул цаашид анги бүлэг дүүрэлтийг зохих түвшинд зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах зөвлөмжийг аймгийн БСУГ-т хүргүүлэв.

Баянхонгор аймагт Галуут сумаас 18 км-т орших “Мандал” багт 17 хүүхэд, Бууцагаан сумаас 45 км-т орших “Баянбүрд” багт 15 хүүхэд, Баянлиг сумаас 45 км-т орших “Гашуун дэл” багт 15 хүүхэд тус тус багийн төвийн бага сургуульд суралцаж байна.

Хүснэгт №04. Бага сургуулиудын үндсэн үзүүлэлт

Хичээлийн жил	Үзүүлэлт	Баянлиг сумын Гашуун дэлийн бага сургууль	Бууцагаан сумын Баянбүрдийн бага сургууль	Галуут сумын Мандалын бага сургууль
2016-2017	Хүүхдийн тоо	12	22	15
	Батлагдсан орон тоо	6	7	10
	Батлагдсан төсөв /2017/	71.0	113.7	104.4
	Нэг албан хаагчид ногдох сурагч /тоогоор/	2	3	2
	Нэг хүүхдэд ногдох зардал	5.9	5.2	7.0
2017-2018	Хүүхдийн тоо	10	19	18
	Батлагдсан орон тоо	7	7	10
	Батлагдсан төсөв /2018/	80.9	120.3	107.3
	Нэг албан хаагчид ногдох сурагч /тоогоор/	1	3	2
	Нэг хүүхдэд ногдох зардал	8.1	6.3	6.0
2018-2019	Хүүхдийн тоо	15	15	17
	Батлагдсан орон тоо	9	7	9
	Батлагдсан төсөв /2019/	132.0	129.3	145.5
	Нэг албан хаагчид ногдох сурагч /тоогоор/	2	2	2
	Нэг хүүхдэд ногдох зардал	8.8	8.6	8.6

Төр засгаас хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэр чухал байгаа ч бага сургуулиудын статистик дүнг харахад хүүхдийн тоо хэт бага нэг ажилтанд ногдох хүүхэд 1-3, нэг хүүхдэд ногдох зардал 5.2-8.8 сая төгрөгийн зардал гарч байгаа нь аймгийн дунджаас хэт өндөр байна.

Мөн аймгийн МХГ-ын барилгын улсын байцаагч нь дээрх 3 сургуулийн барилгын эрсдэлийн үнэлгээ тогтооход “Их” эрсдэлтэй гэж үнэлэгдсэн бөгөөд дахин барилга шинээр барихад их хэмжээний зардал гарах тул үр ашгийн тооцоо хийж, шийдвэр гаргах шаардлагатай байна. Харин дээрх Баянлиг, Бууцагаан сумдад шинэ сум төсөл хэрэгжиж, сургалтын таатай орчныг бүрдүүлсэн байгаа тул бага сургуульд суралцаж

буй хүүхдийг сумын сургуульд суралцахад бүлэг дүүргэлтэд ачаалал үүсгэж нөлөө үзүүлэх нь бага байна.

Хүснэгт №05. Бага сургууль болон сумын сургуулийн бага ангийн анги дүүргэлт

Бүлэг	2016-2019 оны дунджаар /хүүхдийн тоо/								
	Баянлиг сумын сургууль	Гашуун дэлийн баг сургууль	Нийт	Галуут сумын сургууль	Мандалын бага сургууль	Нийт	Бууцагаан сумын сургууль	Баянбүрд багийн бага сургууль	Нийт
1-р анги	29	1	30	23	6	29	26	4	30
2-р анги	29	3	32	19	2	21	27	3	30
3-р анги	26	2	28	30	3	32	26	3	29
4-р анги	23	1	24	24	2	26	23	4	27
5-р анги	26	3	29	23	4	27	23	3	26

Иймд дээрх бага сургуулиудад суралцаж байгаа хүүхдүүдийг сумын төвийн сургуульд нэгтгэх бололцоог судлах зөвлөмжийг БСШУЯ-нд хүргүүлэх саналыг УАГ-ын ГАГ-ын аудитын багт хүргүүлэв.

A.2.1.3. Аймгийн хэмжээнд УТХО-аар 9 сургуулийн барилга баригдаж байгаа ба аудитад хамрагдсан 2016-2018 онд 1 сургууль, 2019-2020 онд 4 сургуулийн барилга ашиглалтад орж, 2020 оны 10-р сарын байдлаар 4 барилга баригдах шатандаа хэрэгжиж байна.

Хүснэгт №06. 2016 оноос хойш УТХО-аар баригдаж буй сургууль

№	Шинээр баригдаж буй сургууль	Хүчин чадал /Хүүхдийн тоогоор/	Ашиглалтад орсон он	Хуучин барилгын			Харьяаллын дагуу хамрагдвал зохих хүүхдийн тоо /2019 оны статистик/	Хамрагдаж буй хүүхэд /2018-2019 хичээлийн жил/
				Хүчин чадал	Ашиглалт	Ашиглалтад орсон он		
1	Баян-Ойт цогцолбор сургууль	250	2018	320	Ашиглах боломжгүй	1977	250	550
2	Өлзийт сумын сургууль /Өргөтгөл/	240	2019	320	Эрсдэл дунд	1977	878	477
3	"Номундалай цогцолбор сургууль	1200	2020	640	Ашиглах боломжгүй	1964	2024	2335
4	Жинст сумын сургууль	240	2020	320	Ашиглах боломжгүй	1978	507	199
5	Баян-Овоо сумын сургууль	240	2020	120	Дотуур байрны зориулалттай	1981	531	133
6	Баянбулаг сумын сургууль /Өргөтгөл/	160	Баригдаж байгаа	160	Эрсдэл дунд	1983	420	284
7	Баянцагаан сумын сургууль /Өргөтгөл/	320	Баригдаж байгаа	320	Эрсдэл дунд	1995	818	641
8	Баянхонгор сумын 5 дугаар 10-н жилийн сургууль /шинээр/	960	Баригдаж байгаа	-	-	-	1082	-
9	Баянхонгор Шинэ суурьшлын бүсийн сургууль	640	Баригдаж байгаа	-	-	-	-	-
Сургуулийн дүн		4250	-	2200	-	-	6510	
1	Жинст сумын дотуур байр	150	2020	75	Их эрсдэлтэй	1979	-	64
2	Сургуулийн дотуур байрын барилга, 100 ор / Баянхонгор сум, 2, 7, 9 дүгээр баг/	100		-	-	-	-	-
Дотуур байрны дүн								

Хүснэгтээс харахад Өлзийт, Баянбулаг, Баянцагаан, Баян-Овоо, Жинст сумд 1 ээлжээр хичээллэх боломжтой болсон байна.

Баян-Овоо, Жинст сумдын ЕБС зориулалтын хэвийн үйл ажиллагаа явуулах байргүй нөхцөл үүссэн байсан бөгөөд шинээр төлөвлөсөн барилгын хүчин чадлыг хамрагдвал зохих хүүхдийн тоогоор тооцоолсон хэдий ч аймгийн төвтэй зэргэлдээ байршилтайгаас Баян-Овоо сумын 531 хамрагдвал зохих сурагчдын 30 орчим хувь, Жинст сумын 507 хамрагдвал зохих сурагчдын 40 орчим хувь нь тухайн сумдаа хамрагдаж, бусад хүүхэд аймгийн төвийн сургуульд хамрагдаж байна. Харин шинэ сургууль ашиглалтад орсноор сүүлийн 2 жилийн элсэн сурагчид нэмэгдэж байгаа сайн үзүүлэлт ажиглагдаж байна.

Аудитын илрүүлэлт:

- “Баянхонгор сумын 9 дүгээр багт 960 хүүхдийн суудалтай сургуулийн барилга 2012 оноос эхлэн баригдаж байгаа ч тус барилга гүйцэтгэгчээс шалтгаалж одоог хүртэл ашиглалтад ороогүй байна.
- Харин Баянхонгор сумын “Шинэ суурьшлын бүс” /одоогийн байдлаар хүн ам суурьшаагүй/-д 640 хүүхдийн сургуулийн барилга нэмж төлөвлөж, барилгын ажил 2019 оноос баригдаж байгаа бөгөөд тухайн бүсэд хүн ам суурьшиж эхэлтэл хөрөнгийн үр ашиг гарахааргүй байна.
- Эрдэнэцогт сумд багийн сургууль, цэцэрлэгийн цогцолбор бүхий барилгыг аймгийн ОНХС-ийн 158.2 сая төгрөгийн хөрөнгөөр 2019 онд ашиглалтан оруулсан ч тус барилгад цэцэрлэгийн 1 бүлэг хичээллэж байгаа боловч сургуулийн зориулалттай ангид ширээ, сандал, самбар байхгүй сургалтын үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдээгүй байна.

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд шинээр төлөвлөгдөн баригдаж байгаа сургуулийн баригдах явцад тавих хяналт сул, ирээдүйд өгөх үр ашгийг тооцож, нэн хэрэгцээ шаардлагатай хөрөнгийг эрэмбэлээгүй байна.

Иймд цаашид төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг гарах өнөөгийн нөхцөл байдлыг оновчтой тооцож, хэрэгцээ шаардлагын эрэмбийг тогтоон төлөвлөлтийг бодитой хийх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

A.2.2.1. Аймгийн МХГ-аас 2019 оны 9 дүгээр сарын байдлаар аймгийн хэмжээний ЕБС-ын 29, барилгад төлөв байдлын үнэлгээ хийсэн байна. Үүнээс гол үзүүлэлтээс дурдвал:

- Нийт 29 сургуулийн 26 нь зориулалтын барилгатай 3 нь зориулалтын бус барилгатай. /Багийн 3 сургуулийн барилга зориулалтын бус/
- 1970 оноос өмнө баригдсан 1, 1971-1990 онд баригдсан 19, 1991-2000 онд баригдсан 1, 2001 оноо хойш 8 /1970 оноо өмнө Номундалай ахлах сургууль/
- Газар хөдлөлтийн 7 баллд тэсвэртэй 7, 8 баллд тэсвэртэй 16, 9 баллд тэсвэртэй 7,
- Их засвар хийгдэж байсан 15, Их засвар хийгдээгүй 15
- Улсын комиссоор хүлээж авсан 26 улсын комисс хүлээж аваагүй 4 / Үүнд 3 бага сургууль, Шаргалжуутын сургууль/
- Дунд эрсдэлтэй 25, их эрсдэлтэй 4 /Үүнд 3 бага сургууль, Номундалай ахлах сургууль/

Мэргэжлийн хяналтаас их эрсдэлтэй гэж үнэлэгдсэн дээрх 4 сургуулиас “Номундалай” ахлах сургууль нь шинээр баригдаж 2020 онд ашиглалтад орсон бөгөөд багийн сургуулиуд нь их эрсдэлтэй түвшинд хичээллэж байна.

2016-2018 онд нийт 10 сургуулийн болон дотуур байрны барилгад 1283.6 сая төгрөгийн засвар хийсэн байна.

Хүснэгт № 07. 2016 оноос хойш УТХО-аар их засвар хийгдсэн сургууль /сая.төг/

№	Сургуулийн нэр		Эх үүсвэр	Төсөвт өртөг	Тайлбар
1	Баянговь	сумын сургууль	ДЗОНХХ, УТХО, ОНХС	213.0	2016 онд их засварыг ДЗОНХХ-2-оос 125 сая, улсын төсвөөс 70 сая, ОНХС-аас 18 сая нийт 213 сая төгрөгийн их засвар хийсэн.
2	Гурванбулаг	сумын дотуур байр	УТХО	50.0	2016 онд дотуур байранд улсын төсвийн 50 сая төгрөгөөр хаалга, цонх, шалны их засвар хийж ашиглалтад хүлээлгэн өгсөн.
3	Хүрээмарал	сумын сургууль	УТХО	65.0	2016 онд хичээлийн байрны барилга, спорт заалны дээврийн их засварыг улсын төсвийн 65 сая төгрөгөөр хийсэн.
4	Эрдэнэцогт	сумын сургууль	УТХО	138.0	2017 онд дотор гадна засал, халаалтын ажил хийгдэж чанаргүй хийсэн ажилд гүйцэтгэлийн аудитаар албан шаардлага өгч байсан.
5	Өлзийт сумын дотуур байрны засвар		УТХО	79.6	2017 онд Өлзийт сумын сургуулийн дотуур байрны их засварыг улсын төсвийн 79,6 сая төгрөгөөр хийсэн.
6	Шинэжинст	сумын сургууль	УТХО	45.0	2018 онд Шинэжинст сумын сургуулийн дотуур байрны сантехникийн их засвар улсын төсвийн хөрөнгөөр 45.0 сая төгрөгийн их засвар хийж ашиглалтад хүлээн авсан.
7	Баян-Өндөр	сумын сургууль	УТХО	80.0	2018 онд сургуулийн гадна шугам сүлжээний засварыг улсын төсвийн 80.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн
8	Гурванбулаг	сумын сургууль	УТХО	280.0	2019 онд сургуулийн их засвар 280 сая төгрөгөөр засварлаж ашиглалтад хүлээн авсан
9	Шинэжинст	сумын сургууль	УТХО	253.2	2019 онд хичээлийн байрны дээврийн засвар болон дотор шал, хананы заслын их засвар хийсэн.
Нийт дүн				1203.8	

УТХО-аар хийгдсэн дээрх засварын ажлууд нь сургалтын таатай орчныг бүрдүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангахад чухал нөлөө үзүүлсэн байна.

A.2.2.2. ЕБС-ууд анги танхимыг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэх талаар аймгийн МХГ-ын боловсролын хяналтын улсын байцаагчийн нэгдсэн удирдамжаар хийсэн шалгалт болон ажлын тайланд тулгуурлан МХГ-ын улсын байцаагчаар судалгаа гаргуулахад зарим сургууль нь лаборатори хичээлийн зориулалтын анги танхимгүй, шаардлага хангаагүй, 6 настай хүүхдийн ширээ сандал нь хуучирч муудсан, анги танхимын нэг хүүхдэд ногдох талбайн хэмжээ хүрдэггүй, анги танхим, өрөө тасалгааны хүрэлцээгүйгээс хичээлийн байрныхаа коридор, “вестибюль”-ийг анги танхим, өрөө тасалгаа болгон зориулалтыг нь өөрчилдөг зэрэг зөрчилтэй асуудлууд илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- “Номундалай”, “Номгон”, “Эрдэнэмандал”, “Эрдэм” Баянцагаан, Өлзийт, Эрдэнэцогт, Бууцагаан, Баян-Овоо, Өлзийт сумдаас бусад сумд хими, физик, биологийн кабинетийн тавих шаардлага /агааржуулалт тусгаарлалт/ хангаагүй, төвийн болон тойргийн бүрэн дунд сургуулиас бусад сургуулиуд тусгай урвалж бодис болон түүнийг хадгалах цоож бүхий сейф, тоног төхөөрөмж нь дутагдалтай байна.
- Жаргалант, Өлзийт, Шаргалжуут, Баян-Өндөр сумдын сургуулиуд нь 6 настай хүүхдийн бие бялдын хөгжилд таарсан ширээ сандал байгаа хэдий ч чанаргүй нийлүүлэгдснээс эдэлгээний хугацаа богиносж хүүхдийн аюулгүй байдалд нөлөөлж байна.

Иймд орчны нарийвчилсан үнэлгээ хийж 6 настай хүүхдийн бие бялдын хөгжилд тохирсон ширээ, сандал болон физик, хими, биологи, технологийн хичээлүүдийн материаллаг орчныг бүрдүүлэх төсвийн тооцоог хийж байгууллагын төсвийн төсөлд тусгаж, эрх бүхий байгууллагад хүргүүлж байх зөвлөмжийг ЕБС-ийн захирлууд болон аймгийн БСУГ-т хүргүүлэв.

A.2.2.3. МУ-ын Ерөнхийлөгчийн өгсөн чиглэлийн дагуу БСШУСЯ-ны 2018.10.15-ны өдрийн № 4/11999 тоот албан бичгээр “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг дотуур байрны орчны аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийх” нэгдсэн удирдамж гаргаж ирүүлсний дагуу аймгийн БСУГ нь аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг 2018 оны 10 сард хийсэн байна. Тус үнэлгээгээр: “2 сургууль буюу 6.2% хувь их эрсдэлтэй, 22 сургууль буюу 68.8% хувь нь дунд эрсдэлтэй, 8 сургууль буюу 25% бага эрсдэлтэй үнэлэгдсэн байна. Үүнээс МХГ-ын улсын байцаагчийн дүгнэлтээр Номундалай цогцолбор сургууль, Шаргалжуут сумын сургуулийн барилгыг цаашид ашиглах боломжгүй гэсэн дүгнэлт гарсан” гэж тайлагнасан байна.

Хүснэгт №08 ЕБС-ийн гадаад орчны аюулгүй байдлын үнэлгээ

д/д	Сургалтын гадаад орчны аюулгүй байдал	Бага эрсдэлтэй	Дунд эрсдэлтэй	Их эрсдэлтэй	Нийт оноо	Дундаж
1	Гэрэлтүүлэг	9	16	7	66	2.1
2	Хашаа хайс	12	15	5	71	2.2
3	Сургуулийн орчны цардсан зам талбай	13	14	5	72	2.25
4	Үүдний шат довжооны хэсэг плитагаар хийгдсэн эсэх	15	11	5	72	2.25
5	Биеийн тамирын талбай	5	14	12	55	1.7
6	Цахилгаан утас, шит	12	11	9	67	2.1
7	Дээвэр	17	8	7	74	2.3
8	Авто замын тэмдэг, тэмдэглээ, хурд сааруулагч	9	13	10	63	1.9

Хүснэгт №09 ЕБС-ийн дотоод орчны аюулгүй байдлын үнэлгээ

д/д	Сургалтын дотоод орчны аюулгүй байдал	Бага эрсдэлтэй	Дунд эрсдэлтэй	Их эрсдэлтэй	Нийт оноо	Дундаж
1	Дотор цахилгааны мантож	11	12	9	66	2.1
2	Сантехник	12	17	3	73	2.3
3	Цонх	15	11	6	73	2.3
4	Хаалга	15	9	8	71	2.2
5	Шатны аюулгүй байдал	19	10	3	80	2.5
6	Үүд коридорын аюулгүй хэсгийг халтирч болзошгүй плитагаар хийгдсэн эсэх	7	20	4	65	2.0
7	Ариун цэврийн байгууламжийн хуртээмж, ариутгал халдваргүйтгэл	8	16	8	64	2.0
8	Цайны газрын ариутгал, халдваргүйтгэл	20	9	3	81	2.5

ЕБС-ууд нь хүүхэд хамгаалах чиглэлээр “Сургуулийн орчинд хүүхэд хамгааллын бодлого”, “Хүүхэд хамгааллын журам” зэргийг боловсруулан баталж түүндээ хохирогчид тасралтгүй боловсрол олгох, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг зохион байгуулалттай холбоотой заалтуудыг тусгасан бөгөөд “Орчин дахь хүүхэд хамгааллын бодлого” боловсруулан сургуулийн захирлаар батлуулан ажиллаж байна гэсэн мэдээллийг ирүүлсэн.

Аудитын явцад ЕБС-ууд хүүхдийн аюулгүй орчныг бүрдүүлээгүйн улмаас хүүхэд бэртэж гэмтсэн тохиолдол гарсан эсэх талаар аймгийн төвийн сургуулиудаас тодруулахад Эрдэм, Соого сейкео, Эрдэнэмандал ахлах сургуулиуд сургуулийн орчинд гэмтэж бэртсэн хүүхэд байхгүй гэсэн бол “Номундалай” цогцолбор сургуулийн хичээлийн 2 дугаар байрны урд шинээр тавигдсан зам дээр 2019 онд 3 дугаар ангийн хүүхэд машинд мөргүүлсэн” тохиолдол гарсан гэж албан бичгээр ирүүлсэн.

Аудитын илрүүлэлт:

• Аудитын явцад авсан бусад эх сурвалжийн мэдээллээс “Номундалай сургуулийн сурагч намрын спартакиадад оролцох үедээ гэмтэж 2 гараа хугалсан байхад сургуулийн зүгээс анхан шатны тусламж үзүүлээгүй, ийм үед хэрхэн ажиллах талаар багш болон сурагчид нь анхан шатны тусламж үзүүлэх мэдлэггүй байсан /түргэн ч дуудаагүй/ тохиолдол гарсан байхад тус асуудлыг гаргаж ирүүлээгүй байна.

Үүнээс үзэхэд сургуулийн удирдлага, менежер, ХАБ-ын ажилтан ажилдаа хариуцлагагүй хандаж байгаа болон гадна, дотоод орчны аюулгүй байдлыг материаллаг талаас нь илүүтэй анхаараад сургалт, сурталчилгаа, мэдлэг олгох талыг орхигдуулсан, хүүхдийн сурах орчинд юуг аюул, осол гэж үзэх талаарх ойлголт ЕБС-ууд байхгүй байгаа тул ямар ч мэдээлэл бүртгэгдэхгүй ирсэн байна.

Иймд сургуулийн гадаад болон дотоод орчинд тулгарч болох эрсдэлийн жагсаалт гарган холбогдох мэргэжлийн байгууллагаас багш, сурагч, ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулж, мэдээллийн сан үүсгэх ажлыг зохион байгуулах, эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гарсан сургуулиудын эрсдэлийг бууруулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллан биелэлтийг тооцож ирүүлэх зөвлөмжийг аймгийн БСУГ-т хүргүүлэв.

A.2.2.4. Аудитад хамрагдаж буй 2016-2018 онуудад Баян-Ойт сургуулийн барилга шинээр ашиглалтад орсон бөгөөд БСШУЯ-аас 2017 онд 3.9 сая, 2019 онд 18.0 сая төгрөгийн өртөг бүхий тавилга эд хогшил нийлүүлсэн /нэг бүр нь 0.3 сая төгрөгийн өртөг бүхий 13 ширхэг номын тавиур, 108 ширхэг ширээ 7.1 сая 108 сандлыг 3,3 сая г.м/-ийг үндсэн хөрөнгөд бүртгэсэн нь бүрэн хүрэлцээтэй, чанарын шаардлага хангаж байна.

A.2.2.5. Сургалтын үйл ажиллагаанд сурагчдын тээврийн хэрэгсэл хэрэглэдэг сургууль байхгүй байна.

2016-2019 онд төсөл, хөтөлбөр, хандив тусламж болон төсвийн хөрөнгөөр бэлтгэгдсэн техник хэрэгсэл тоногт төхөөрөмжийг газар дээр нь тулган баталгаажуулалт хийхэд 3 төрлийн 1.4 сая төгрөгийн хөрөнгийг бүртгээгүй, 15,6 сая төгрөгийн бэлтгэн нийлүүлэгч байгууллагад мөнгийг шилжүүлсэн ч хөрөнгийг хүлээн аваагүй, 32.9 сая төгрөгийн хөрөнгө ашиглалтгүй зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- Хүрээмарал сумын 9 жилийн дунд сургууль 73.4 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэснээс 12,5 сая төгрөгийн хөрөнгийг бэлтгэн нийлүүлэгч “Өгөөж марал” ХХК нь нийлүүлээгүй.
- Гурванбулаг сумын сургууль 140.2 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэснээс 3,1 сая төгрөгийн хөрөнгийг бэлтгэн нийлүүлэгч “Мөнх-Ундрах эрдэнэ” ХХК нь нийлүүлээгүй байгаа тул төлбөрийн нийт 15,6 сая төгрөгийг тухайн сургуулийн дансанд буцаан төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов..

Аудитын илрүүлэлт:

- Эрдэнэцогт сумын сургууль 2016 онд байгалийн ухааны кабинетийн 3.7 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмжийг хүлээж авсан бөгөөд 1,4 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй тул хөрөнгийг орлогод авах албан шаардлага хүргүүлэв.
- Аймгийн төвийн “Номундалай”, “Номгон”, “Эрдэнэмандал”, “Эрдэм” ахлах сургуулиудад 32.9 сая төгрөгийн шүдний тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн боловч, мэргэжлийн эмч байхгүйгээс хөрөнгийн үр ашиг гараагүй байна.

Иймд тухайн хөрөнгийг цаашид хэрхэн ашиглах талаар шийдвэр гаргаж, төсвийн хөрөнгийн үр ашгийг гаргах зөвлөмжийг аймгийн ОНӨГ-т хүргүүлэв.

A.2.3.1. 2019-2020 оны хичээлийн жилийн байдлаар аймгийн хэмжээд нийт 886 багш үндсэн багшаар ажиллаж байгаа бөгөөд үүний 46,5 хувь нь аймгийн төвд, 53,5 хувь нь сум болон багийн сургуульд ажиллаж байна.

Хүснэгт № 10. ЕБС-уудад ажиллаж буй багшийн судалгаа

Сургууль	Нийт	Үүнээс		
		Бага анги	Дунд анги	Ахлах анги
Аймгийн төв	412	133	139	140
Сумд	468	174	229	65
Багийн бага сургууль	6	6		
НИЙТ	886	313	368	205

Аудитаар ЕБС-уудад одоо ажиллаж байгаа багш нарын хувийн хэргээс төгссөн сургуулийнх нь өмчийн хэлбэрээр нь дүн шинжилгээ хийж үзэхэд нийт багш нарын дийлэнх буюу 73.5 хувь нь төрийн өмчийн их, дээд сургууль төгссөн бол 26.1 хувь нь төрийн бус өмчийн их, дээд сургууль төгсөж багшийн мэргэжил эзэмшсэн байна.

Дүрслэл №02. Багшийн тоо /төгссөн сургуулиар/



Аудитаар аймгийн хэмжээний ЕБС-ийн багш ажилчдын мэргэжлийн байдалд дүн шинжилгээ хийхэд аймгийн 29 сургуулиас 25 сургуульд 1-4 багш буюу нийт 33 багш, 2 номын санч мэргэжлийн бус байна.

Дээрх мэргэжлийн бус багшийн гол эзлэх хувийг технологийн болон дуу хөгжмийн багш эзэлж байгаа бөгөөд /Хүснэгт № 12-с харна уу/ тухайн мэргэжлийн багш нар нь орон нутагт дутагдалтай, БСУГ ажлын байрны сонгон шалгаруулалтыг удаа дараа зарласан боловч дээрх мэргэжлийн багш оролцдоггүйтэй холбоотой байна.

Хүснэгт № 11. ЕБС-уудад ажиллаж буй мэргэжлийн бус багш, ажилчдын судалгаа

Үзүүлэлт	Монгол хэл	Математик	Физик	Хими	Түүх	Нийгэм судлал	Дүрслэх урлаг	Хөгжим	Зураг зүй	Технологи	Биеийн тамир	Англи хэл	Иргэний боловсрол	Номын санч	Бага ангийн багш	НИЙТ
Номгон														1		1
Эрдэнэмандал	1														1	2
Соогоо сейко						1				1			1	1		4
Баянбулаг										1						1
Баянговь										1						1
Баян-Овоо			1			1										2
Баян-Өндөр								1								1
Шаргалжуут					1		1		1	1						4
Баянцагаан				1												1
Богд		1														1
Бөмбөгөр				1						1						2
Бууцагаан											1	1				2
Галуут								1		1						2
Гурванбулаг			1													1
Жаргалант															1	1
Жинст										1						1
Заг			1					1								2
Өлзийт								1								1
Хүрээмарал										2		1				3
Шинэжинст										1						1
Эрдэнэцогт								1		1						2
НИЙТ	1	1	3	2	1	2	1	5	1	11	1	2	1	2	2	35

Мөн сумдын 9 жилийн бүх анги нь 1 бүлэгтэй сургуулиудад газарзүй, физик, хими, биологи, мэдээлэл зүй гэх мэт хичээлүүдийн жилийн цагийн нийлбэр нь БСШУ-ны сайд, НХХ-ийн сайд, Сангийн сайдын 2007 оны 307/91/237 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам”-ын 11⁴-т заасан 1 багшийн нормт цагт хүрэхгүй байгаагаас зарим хичээлийг хавсарч орж байгаа нь мэргэжлийн бус багш хичээл заах гол шалтгаан болж байгаагаас сумдын сургуулиудын хувьд *хос мэргэжилтэй* багшийн хэрэгцээ их байгаад салбарын хэмжээнд бодлого барьж ажиллах шаардлагатай байна.

Гэвч дээрх мэргэжлийн бус зарим багш нарын сургаж буй сурагчдын сурлагын амжилт сайн байх тохиолдол гарч байна. /Тухайлбал: Соого сейко сургуулийн нийгэм судлалын багш, Жинст сумын технологийн багшийн гаргасан амжилтаас үзэхэд бэлтгэсэн шавь нь ЭЕШ-ын дундажаас өндөр үнэлгээ авсан байна./

Иймд дээрх мэргэжлийн бус багш, ажилчдыг хөрвөх сургалтад хамруулах, мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангах арга хэмжээг зохион байгуулж ажиллах зөвлөмжийг аймгийн БСУГ-т хүргүүлэв.

A.2.3.2. Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт “Сайн багш” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгаж, жил бүрийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд оруулан биелэлтийг тооцож иржээ.

1. Багш нарын “Багш бол тухайн салбарын тэргүүлэх мэргэжилтэн-судлаач, сэтгэл зүйч-дидактикч, менежер байна” гэсэн дэлхийн хэмжээнд тавьж байгаа шаардлагыг хангаж ажиллах, мэдлэг чадварыг дээшлүүлэх
ХЭРЭГЖИЛТ: 1. Дидактик, сэтгэл судлал, менежментийн онолын мэдлэгийг сэргээх сургалтыг хөтөлбөр ба модуль боловсруулж зохион байгуулсан бөгөөд 4 жилийн хугацаанд 400 гаруй багшийг хамруулсан. Сургуулийн захирал, сургалтын менежер, багш, нийгмийн ажилтан, дотуур байрын багш нарыг сургалт семинарт хамруулан багш нараас мэргэжлийн шалгалт авахад эхний шалгалтад 46 хувийн ажилттай, 7,9 хувийн чанартай байсан бол 2 дахь шалгалтаар “F” үнэлгээ авсан багшийн тоо 101 хүнээр буурч амжилт 9,6 хувь, чанар 2,8 хувиар өссөн дүнтэй байна.
2. Багш, багшлах ажилдаа чих сэтгэлээсээ, хариуцлагатай, ухамсартай хандаж, ажиллах сэтгэлгээ, хандлага төлөвшүүлэх
ХЭРЭГЖИЛТ: Сургалтын цөм хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн боловсролын чанарыг сайжруулах зорилгоор “Судалгаат хичээл-ур чадварын уралдаан”-ыг аймгийн хэмжээнд зохион байгуулж энэхүү арга хэмжээний хүрээнд сургалтын хөтөлбөр боловсруулах, түүнийгээ хэрэгжүүлэх чадварыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой ажил болсон гэж дүгнэсэн байна.
3. Багш сайн ажиллах, өөрийгөө хөгжүүлэхэд нь үзүүлэх төр захиргааны байгууллагын “дэмжлэг” ба туслалцааг тодорхойлж, эрх зүйн зохицуулалттай болгох
ХЭРЭГЖИЛТ: Багш сайн ажиллах, өөрийг хөгжүүлэхэд нь төр захиргааны байгууллагын “дэмжлэг ба туслалцаа” баримт бичгийг аймгийн Засаг даргын захирамжаар батлуулснаар аймаг, сумын Засаг дарга БСУГ, сургуулийн захирал тус бүрийн үзүүлэх дэмжлэг туслалцаа тодорхой болсон. Мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулж 1,5,10 дахь жилдээ ажиллаж буй 2017 онд 186, 2018 онд 139, 2019 онд 139 багшид тасралтгүй боловсролын сургалтад суух нөхцөл бололцоог хангаж ажилласан байна.
2018 ОНООС ДЭЭРХ 3 ЗОРИЛТ ДЭЭР НЭМЖ 2 ЗОРИЛТЫГ ДЭВШҮҮЛСЭН БАЙНА.
4. Аймгийн хэмжээнд “Сайн багш” –ийг тодруулдаг оновчтой арга зүйг тогтоох
ХЭРЭГЖИЛТ: 4. Сайн багш шалгуур /3 шалгуур 9 үзүүлэлттэй/, “Сайн багш”-ийг тодруулах үйл ажиллагааны аргачлал” баримт бичгүүдийг боловсруулж аймгийн засаг даргын захирамжаар батлуулсан, “сургууль цэцэрлэг, бүс, аймгийн сайн багш нарт олгох урамшуулал, үзүүлэх дэмжлэг” баримт бичгийг боловсруулсан, аймгийн засаг

⁴. Сургуулийн багш долоо хоногт 34 цагтай тэнцэх стандартыг хэрэгжүүлэх ажил, 6 цагтай тэнцэх бусад ажлыг тус тус гүйцэтгэнэ. Стандартыг хэрэгжүүлэх ажилд ногдох 34 цагийн 19 цаг нь хичээл заах цагт зориулагдана.

даргын зөвлөлөөр хэлэлцүүлсэн, “сайн багш тодруулах аргачлалыг зөв хэрэгжүүлэх чиглүүлэг, зөвлөмж” баримт бичгүүд гарсан.

5. Багшийн амжилт олон нийтэд мэдээлэгдэх бололцоо бүрдүүлэх

ХЭРЭГЖИЛТ: Багш нарын “багшийн амжилт”-ын бүртгэл мэдээллийн бааз үүсгэн, сайтын загвар дизайн, ашиглах хэлбэрийг тодорхойлон веб хийх гэрээгээ байгуулсан боловч түр хойшлогдсон.

Аудитаар ЕБС-уудын багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг шалгахад бүх сургуулиуд нь “Сайн багш” хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө гарган 5 зорилт тавьж ажиллан, хагас, бүтэн жилээр хэрэгжилтийг тооцсон байна.

“Сайн багш” хөтөлбөрийн хүрээнд багш нарыг сургалтад хамруулж, төрөл бүрийн уралдаант шалгаруулалт зохион байгуулж, багш нараас шалгалт авч түвшнийг тогтоон шалгалтын амжилтыг ахиулах арга хэмжээ авч байгаа нь ололттой ажиглагдаж байна.

Гэвч бодлого хэрэгжүүлж буй орон нутгийн түвшинд тус хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах, цаашид авах арга хэмжээг хэрхэн тодорхойлох, мэдээллээр хангах асуудал дутмаг хариуцаж буй мэргэжилтнүүд нь хариуцлагагүй хандаж байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

• Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс нь аудитад “Сайн багш” хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг гаргаж өгөхдөө 2018, 2019 оны тайланг гаргаж өгөхдөө зөвхөн гарчиг болон нийт биелэлтийн хувийг өөрчлөн бусад тоон үзүүлэлт, зохион байгуулсан ажлын огноо зэрэг нь үг үсэггүй адилхан гаргаж өгч байгаа нь аудитын шалгалтыг аргацаах гэсэн ажлын хариуцлагагүй байдал гаргаж байна.

Иймд орон нутгаас баримталж байгаа бодлогыг хэрэгжүүлэх, түүний биелэлтийг үнэн зөв тайлагнаж, хөтөлбөрийн биелэлтийг гаргаж буй холбогдох албан тушаалтны ажлын хариуцлагыг сайжруулж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад өглөө.

A.2.3.3. Төрийн албаны зөвлөлөөс гаргасан албан тушаалын тодорхойлолтын үлгэрчилсэн загварын дагуу ЕБС-ууд нь өөрийн дотоодод баримтлах албан тушаалын тодорхойлолтыг боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, тусгай шаардлага гэсэн гол 5 үндсэн шаардлагыг тусгаж баталсан байна.

Аудитаар албан тушаалын тодорхойлолтод нийцэж буй эсэх талаар албан хаагчийн хувийн хэрэг бүрийг авч үзэн тулган шалгахад дараах зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- Аудитаар нийт аймгийн хэмжээнд нийт 35 багш мэргэжлийн бус / Хүснэгт № 7/ ажиллаж байгаа бөгөөд бусад шаарлагыг хангахгүй байгаа дараах албан хаагчид байна.
- Баян-Ойт сургуулийн Нийгмийн ажилтан, Эрдэнэмандал сургуулийн бага, Номгон ахлах сургуулийн багын болон дундын 2 менежер тушаалын тодорхойлолтод тавигдах шаардлага хангаагүй.
- Баян-Өндөр сумын сургуулийн дуу хөгжмийн багш нь багшлах эрхийн үнэмлэхгүй
- Баянбүрд бага сургуулийн 2 багшийн багшлах эрхийн үнэмлэхний хугацаа дууссан
- Бөмбөгөр сумын сургуулийн 6 багшийн багшлах эрхийн үнэмлэхний хугацаа дууссан.
- Жинст сумын сургуулийн технологийн багш багшлах эрхгүй.

- Соого сейко сургуулийн 1 багшийн багшлах эрхийн үнэмлэхний хугацаа дууссан.
- Эрдэм ахлах сургуулийн дуу хөгжмийн багш багшлах эрхгүй,
- Номгон ахлах сургуулийн Насан туршийн боловсролын менежер “НТБ, холимог бүлгийн сургалтанд хамрагдсан байх” гэсэн шаардлагыг хангахгүй байна..

2018 онд батлагдсан “Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.5⁵-т багшлах эрх харгалзахгүй болжээ.

Харин багшлах эрхээс бусад ажлын байрны үндсэн шаардлага хангахгүй байгаа дээрх албан хаагчдыг ажлын байрны шаардлагад нийцүүлэх зөвлөмжийг БСУГ-т хүргүүлэв.

A.2.3.4. Салбарын яамны хүний нөөцийн бодлого нь орон нутагт хүрч хэрэгжихгүй байгаагаас сумдын сургуульд суралцаж буй хүүхдүүд нь тэгш бус бололцоогоор хангагдаж байна. Тухайлбал:

Аймгийн төвд суралцаж байгаа сурагчид бүх хичээлийг мэргэжлийн багшаар заалгах бололцоотой байхад хөдөө сумдын сургуульд суралцаж байгаа сурагчид нь багшийн батлагдсан орон тоо, төсөв хөрөнгө, батлагдсан ажлын норм норматив зэргээс шалтгаалан зарим хичээлийг мэргэжлийн бус багшаар заалгаж, бага дунд боловсрол эзэмшиж байгаа нь эцэг, эхчүүд хүүхдээ аймгийн төвийн сургуульд оруулах, хамран сургалтыг алдагдуулах гол нөхцөлийн нэг шалтгаан болж байна.

Иймд ЕБС бүрд бүх мэргэжлийн багшийг зайлшгүй байлгах, бололцоог бүрдүүлж, хамран суралцагсдыг сайжруулан сумдын сургуульд хуваарилах төсөв, хөрөнгийг төрөөс дэмжих бодлогыг барьж ажиллах зөвлөмжийг БСШУЯ болон бусад холбогдох шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад хүргэх саналыг ҮАГ-ын ГАГ-ын аудитын багт хүргүүлж байна.

A.2.3.5. Орон нутгийн түвшинд багш нарын эрэлт хэрэгцээний талаар нэгдсэн мэдээлэл мэдээлэл байхгүй байна. Энэ талаар БСУГ-ын мэргэжилтнээс тодруулахад “багшийн эрэлт хэрэгцээний судалгаа байхгүй, харин бага дунд боловсролын статистик мэдээгээр одоогийн багш нарын тоог гаргасан судалгаа л байгаа” гэсэн тайлбар өгөв.

Иймд аймгийн хэмжээний багш нарын эрэлт хэрэгцээний судалгааг сум, байршил, мэргэжил тус бүрээр гарган нэгдсэн сан үүсгэж, дээд шатны шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад санал дэвшүүлэн ажиллах зөвлөмжийг аймгийн БСУГ-т хүргүүлэв.

A.3. Бүх нийтийн ерөнхий боловсролын үйл ажиллагааны санхүүжилтийг зөв хуваарилж, хяналтыг бүрэн хэрэгжүүлдэггүйгээс зардлын хэмнэлтийг төсвийн зохицуулалтаар бусад зардалд дахин хуваарилж зарцуулдаг жишиг тогтсон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1⁶ дэх заалттай нийцэхгүй байна.

A.3.1.1. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1⁷-д заасны дагуу боловсролын салбарын төсвийн төслийг 2016 онд аймгийн БСУГ-ын төсвийн

⁵ Багш мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн төгсөгч нь багшлах эрхтэй байна.

⁶ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

⁷ Төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг төсвийн шууд захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор харьяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлнэ.

мэргэжилтэн, 2017 оноос хойш аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн боловсрол хариуцсан төсвийн мэргэжилтэн нэгтгэн БСШУЯ-нд хүргүүлсэн байна.

Хүснэгт №12: ЕБС-д батлагдсан зардлын үзүүлэлт

сая.төг

Төсөв	2017 он	2018 он	2019 он
БСШУЯ-руу явуулсан төслийн санал	20501.2	21917.2	22105.1
УИХ-д өргөн барьсан төсвийн төсөл	20591.8	21199.6	23409.2
Анх батлагдсан	20644.1	21223.8	23409.2
Батлагдсан төсөв	21057.3	21253.2	27024.8
Үүнээс: Тогтмол зардал	2387.5	3332.1	3641.1
Хувьсах зардал	9385.7	10303.5	14054.2
Нормативд зардал	2840.4	2733.8	2949.5
Бусад зардал	6443.7	4883.8	6380.0

2016-2019 онд Баянхонгор аймгийн СТСХ-ээс БСШУЯ-нд нэгтгэн хүргүүлсэн төсвийн төслөөс харахад цалингийн хувьсах зардлыг тогтоосон нормативаар тооцсон цалингийн зардал нь Засгийн газрын тогтоолоор тогтоосон цалингийн шатлалаар тооцсон цалингийн зардлаас нийт дүнгээр 10805.2 сая төгрөгийн зөрүүтэй байгаа нь одоогийн нөхцөлд байдалд ашиглаж байгаа нормативд зардлын нормыг Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 -д заасны дагуу зайлшгүй шинэчлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Хүснэгт №13: Төсвийн төсөлд өгсөн хувьсах зардлын цалингийн тооцоолол

Он	Хувьсах зардлаар тооцсон цалин	ЗГ-ын тогтоолоор тогтоосон цалингийн сүлжээгээр	Зөрүү
2016	4934.7	8878.5	3943.8
2017	5563.5	7690.6	2127.1
2018	5754.1	8274.2	2520.1
2019	5978.1	8192.3	2214.2
Нийт	22230.4	33035.6	10805.2

Эх сурвалж: Аймгийн СТСХ-ийн хянаж, нэгтгэсэн төсвийн төсөл

Аудитаар ЕБС-уудын 2016-2019 онуудад боловсруулсан төсвийн төслийг Засгийн газрын 2012 оны 94 дүгээр тогтоол, мөн Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор баталсан хувьсах зардлын нормативыг тогтоох аргачлалын 3⁸-р хавсралтад заасны дагуу орон нутгийн онцлог хэв шинжтэй нь уялдуулан зөв төлөвлөж буй эсэхийг шалгахад аймгийн төвийн сургуулиуд анхан шатандаа 175.0 сая төгрөгөөр төсвийн төслийг илүү төсөвлөсөн зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- "Номундалай" цогцолбор сургууль нь дээрх аргачлалын дагуу 2019 оны төсвийн төсөлд аймгийн төв болон нийслэлийн захын дүүрэгт гэсэн ангиллаар хувьсах зардлын нормыг тооцох байтал Аймгийн төвөөс бусад сум гэсэн ангиллаар тооцож 69.8 сая төгрөгөөр;
- "Баян-Ойт" цогцолбор сургууль нь 2019 оны төсвийн төслийг боловсруулахдаа дээрх аргачлалын дагуу Аймгийн төв болон нийслэлийн захын дүүрэгт гэсэн ангиллаар хувьсах зардлын нормыг тооцох байтал Аймгийн төвөөс бусад сум гэсэн ангиллаар тооцож 12.9 сая төгрөгөөр;
- "Номгон" ахлах сургууль нь 2019 оны төсвийн төслийг боловсруулахдаа дээрх аргачлалын дагуу Аймгийн төв болон нийслэлийн захын дүүрэгт гэсэн ангиллаар хувьсах зардлын нормыг тооцох байтал Аймгийн төвөөс бусад сум гэсэн ангиллаар тооцож 56.0 сая төгрөгөөр;

⁸ Аймгийн төвийн болон нийслэлийн захын дүүрэгт бага ангид 315,4 мянга, дунд ангид 449,8 мянга, ахлах ангид 458,4 мянган төгрөг байна.

- "Эрдэм" ахлах сургууль нь 2019 оны төсвийн төслийг боловсруулахдаа дээрх аргачлалын дагуу Аймгийн төв болон нийслэлийн захын дүүрэгт гэсэн ангиллаар хувьсах зардлын нормыг тооцох байтал Аймгийн төвөөс бусад сум гэсэн ангиллаар тооцож 36.3 сая төгрөгийн төгрөгөөр тус тус илүү төсөвлөсөн ч дээрх алдааг аймгийн ЗДТГ-ын СТСХ нь төсөв нэгтгүүлэхдээ залруулан БСШУЯ-нд хүргүүлсэн байна.


Иймд тус сургуулиудын холбогдох албан тушаалтнуудад алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, түүнд хяналт тавих зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлэв.

A.3.1.2. 2017-2019 онуудын батлагдсан төсвийг зардлын төрлөөр нь харьцуулбал тогтмол зардал нь нийт зардлын 11.5-15.7 хувь, Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал 46.9-54.7 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд нийт батлагдсан төсөв 2018 онд 2.59 хувиар, 2019 онд 27.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл №03 Батлагдсан төсөв /зардлын төрлөөр/



Дүрслэл №04 Батлагдсан төсвийн бүтэц



Хүснэгт №14: 2017-2019 онуудын батлагдсан төсвийг зардлын төрлөөр харьцуулав.

сая.төг

Зардлын төрөл	2017 он	Эзлэх хувийн жин	2018 он	Эзлэх хувийн жин	2019 он	Эзлэх хувийн жин	Өсөлт, бууралт	
							2018/2017	2019/2018
Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	9,385.8	44.57	10,303.5	48.5	14,054.2	52.0	1.10	1.36
Үдийн цай хөтөлбөр	749.7	3.56	788.3	3.7	793.4	2.9	1.05	1.01
Дотуур байрны үйлчилгээ	2,090.7	9.93	1,945.5	9.2	2,156.1	8.0	0.93	1.11
Тогтмол зардал	2,375.5	11.28	3,332.1	15.7	3,641.1	13.5	1.40	1.09
Бусад зардал	6,420.2	30.49	4,220.6	19.9	6,257.4	23.2	0.66	1.48
Насан туршийн боловсрол	11.0	0.05	11.0	0.1	20.0	0.1	1.00	1.82
Хувийн сургуулиуд	24.4	0.12	6.0	0.0	102.6	0.4	0.25	17.10
Нийт зардал	21,057.3	100.00	21,253.2	100.0	27,024.8	100.0	1.01	1.27


Эх сурвалж: 2017-2019 онуудын төсвийн гүйцэтгэлийн тайлан, хэлбэлзэл.

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын сургуулиудад 2017-2019 онуудын батлагдсан төсвийг сургууль бүрээр харьцуулж, нэг хүүхдэд ногдох нийт зардал, нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын судалгаа гаргав.

Хүснэгт №15: 2017-2019 онуудын батлагдсан төсөв сургуулийн төрлөөр.

Огноо	Аймгийн төвийн ерөнхий боловсролын сургууль			Сумын ерөнхий боловсролын сургууль			Багийн сургууль			Зөрүү/хувиар илэрхийлэв/		
	Нэг хүүхдэд ногдох зардал /хамгийн их/	Нэг хүүхдэд ногдох зардал /хамгийн бага/	Нэг хүүхдэд ногдох зардлын дундаж	Нэг хүүхдэд ногдох зардал /хамгийн их/	Нэг хүүхдэд ногдох зардал /хамгийн бага/	Нэг хүүхдэд ногдох зардлын дундаж	Нэг хүүхдэд ногдох зардал /хамгийн их/	Нэг хүүхдэд ногдох зардал /хамгийн бага/	Нэг хүүхдэд ногдох зардлын дундаж	Аймаг, сум	Аймаг, баг	Сум, баг
2017 он	1288.8	653.1	979.5	2821.5	1044.5	1292.7	5969.6	3789.5	4697.9	1.3	4.8	3.6
2018 он	1160.3	674.4	946.3	3092.5	1020.7	1309.7	6583.2	3976.2	4730.5	1.4	5.0	3.6
2019 он	1676.2	922.7	1180.7	2879.5	1271.3	1644.3	6855.0	6025.9	6452.5	1.4	5.5	3.9

Дүрслэл №5. Аймгийн төвийн ЕБС-ийн 2017-2019 онуудын нэг хүүхдэд хуваарилагдсан нийт зардлын харьцуулалт




Аймгийн төвийн ЕБС-удын хувьд 2017 онд нэг хүүхдэд ногдох нийт зардал 653.1-1288.8 мянган төгрөг, 2018 онд 674.4-1160.3 мянган төгрөг, 2019 онд 922.7-1676.2 мянган төгрөг ногдож байна.

Мөн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг харьцуулахад 2017 онд 344.6-609.5 мянган төгрөг, 2018 онд 354.6-659.6 мянган төгрөг, 2019 онд 543.2-

804.2 мянган төгрөг хуваарилагдсан байна.

Дүрслэл №06. Аймгийн төвийн ЕБС-ийн 2017-2019 онуудын нэг хүүхдэд хуваарилагдсан хувьсах зардлын харьцуулалт



Сумдын сургуулиудын хувьд 2017 онд нэг хүүхдэд ногдох зардал нийт зардал 1.0-2.8 сая, 2018 онд 1.0-3.1 сая, 2019 онд 1.3- 2.9 сая төгрөг буюу аймгийн төвийн сургуулиудаас 1.5 дахин их зардал хуваарилагдсан байна. Үүнээс 2017 онд Баян-


Овоо сумын нэг хүүхдэд 2.8 сая төгрөг буюу хамгийн их зардал, Баян-Өндөр сумын нэг сурагчид 1.0 сая төгрөгийн зардал ногдож байна.

Дүрслэл №07 Нэг хүүхдэд ногдох нийт зардал

2017-2019 онуудын нэг хүүхдэд ногдох нийт зардлын үзүүлэлт /дундаж/



Дүрслэл №8. Багийн сургуулиудын нэг хүүхдэд ногдох хувьсах зардал /2017-2019 он/



Харин 2019 онд сумын багийн төвийн сургуулийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардал 2.0-3.8 сая, нийт зардал 6.0-6.9 сая байгаа бөгөөд аймгийн төвийн сургуулийн нэг хүүхдэд ногдох зардлаас 5.4 дахин, сумын төвийн сургуулийн нэг хүүхдэд ногдох зардлаас 3.6 дахин их буюу хэтэрхий өндөр зардалтайгаар боловсрол олгож байна.

Дээрхээс үзэхэд төрөөс санхүүжүүлж байгаа нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг сургуулийн сурагчдын тоо, газар зүйн байршил зэргээс шалтгаалан харилцан адилгүй хуваарилж байна.

А.3.1.3. 2016-2019 онуудын аймгийн СТСХ-ээс хянаж, нэгтгэсэн төсвийн төслийг нэг бүрчлэн дотуур байрны хүүхдийн хоолны зардлын төлөвлөлтийг тулган баталгаажуулахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд: Аудитын илрүүлэлт:

- Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс нь ерөнхий боловсролын сургуулиудаас ирүүлсэн төсвийн төсөлд 6 настай хүүхдийг тусад нь тооцоолсон байхад тухайн төсвийн төслийг хүлээн авч, нэгтгэж, боловсруулахдаа дотуур байранд амьдардаг 6 настай хүүхдийг тусгаагүй орхигдуулсан байна. 2018 онд 6 настай 80 сурагч дотуур байранд амьдарсан бөгөөд 10.8 сая төгрөгийг дутуу төлөвлөсөн байна.
- 2019 онд Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс нь ерөнхий боловсролын сургуулиудаас ирүүлсэн төсвийн төсөлд 6 настай хүүхдийг тусад нь тооцоолсон байхад тухайн төсвийн төслийг хүлээн авч, нэгтгэж, боловсруулахдаа дотуур байранд амьдардаг 6 настай хүүхдийг тусгаагүй орхигдуулсан нь Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор баталсан аргачлал⁹-ыг зөрчсөн ба аймгийн СТСХ БСШУЯ-д нэгтгүүлэхдээ залруулж хүргүүлсэн байна. Иймд холбогдох албан тушаалтнуудад зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

Аудитаар ЕБС бүрийн боловсруулсан төсвийн төслийг тулган баталгаажуулахад 12.3 сая төгрөгийн дутуу төсөвлөсөн зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- 2019 онд ЗГ-ын 2016 оны 242 дугаар тогтоолоор батлагдсан "Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг сурагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээ"-д заасан нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг 312.7 мянган төгрөгөөр тооцох байтал 300.0 мянган төгрөгөөр тооцож нийт 2,1 сая төгрөгийг дутуу төсөвлөсөн байна.

⁹ 6 настай хүүхэд амьдардаг байранд 462.2 мянган төгрөг, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг сурагчид 312.7 төгрөгөөр тус тус тооцно.

- Мөн нэг сурагчид ногдох хоногийн хоолны зардлыг Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор баталсан "Хоолны зардлын дундаж норматив батлах тухай" тогтоолын 3¹⁰-д заасан нормативыг зөрчиж нэг хүүхдэд ногдох зардлыг 2145 төгрөгөөр тооцож, 10.2 сая төгрөгийг дутуу төсөвлөжээ.

Иймд холбогдох албан тушаалтнуудад зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

Харин дээрх алдааг аймгийн ЗДТГ-ын СТСХ нь төсөв нэгтгүүлэхдээ залруулан БСШУЯ-нд хүргүүлсэн байна.

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс нь 2017-2019 онуудын дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 973.8-1028.4 сая төгрөгөөр төлөвлөсөн байхад яамнаас 833.9-808.1 сая төгрөгөөр баталсан байна. Энэ талаар аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтнээс тодруулахад "Сангийн яамнаас бусад аймгууд дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 80%-тай төсөвлөж байхад танай аймаг 90%-иар төсөвлөж байна гэж үзээд дундажлаад хүүхдийн тоог хасдаг" гэсэн тайлбар өгсөн.

Хүснэгт №16: Дотуур байрны хүүхдийн хоолны зардлын төлөвлөгөө гүйцэтгэл

Огноо	Төсвийн төсөлд өгсөн санал		Шаардлагатай төсөв /статистик мэдээ/		Сангийн яамны Э-тайлангаар Батлагдсан төсөв	Зөрүү
	Хүүхдийн тоо	Дүн	Хүүхдийн тоо	Дүн		
2017 он	1743	973.9	1710	951.9	833.9	118.0
2018 он	1840	1028.4	1663	926.9	808.1	118.8

Үүнээс харахад дотуур байрны хүүхдийн хоол хүнсэнд 926.9 - 951.9 сая төгрөгийн хэрэгцээ шаардлага байхад Сангийн яамнаас 2017 онд 118.0 сая төгрөгөөр бууруулан 833.9 сая, 2018 онд 118.8 сая төгрөгөөр бууруулан 808.1 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн шууд захирагч төсвийн төслөө алдаатай төлөвлөж байхад аймгийн төсвийн мэргэжилтэн хүлээж авахдаа хянаж, засуулаагүй байгаа нь, төсвийн төсөлд бүх шатны албан тушаалтнууд ач холбогдол өгөхгүй, төсөв дутагдахад зохицуулалт хийлгээд төсөв авч ирсэнтэй холбоотой байна.

A.3.1.4. БСШУ-ны сайдын 2009 оны 131 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх журам"-ын 5.1¹¹-д зааснаар аймгийн БСУГ нь сургуулийн статистик мэдээнд үндэслэн ном, сурах бичгийн захиалгыг БСШУЯ-д хүргүүлж иржээ.

БСШУ-ны сайдын 2019 оны А/302 тоот тушаалаар "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээний журам"-ыг баталж, 2019 оны А/624 тоот тушаалын дагуу 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн 6-12 дугаар ангийн сурагчдад түрээсийн сурах бичгийг 14.0-21.0 мянган төгрөгөөр ашиглуулсан байна.

Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор баталсан хувьсах зардлын нормативыг тогтоох аргачлалын дагуу нэг хүүхдэд ногдох бусад хувьсах зардлыг орон

¹⁰ "Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг 2315 (хоёр мянга гурван зуун арван таван) төгрөгөөр тогтоосугай"

¹¹ Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар нь сурах бичгийн түгээлт, ашиглалтын талаарх мэдээ, тайлан, нөхөн хангах сурах бичгийн захиалгыг хичээлийн жилийн эхний хагас жилийн болон төгсгөлийн байдлаар жилд хоёр удаа яаманд ирүүлнэ

нутгийн онцлогоос нь хамааруулаад 13.9-42.8 мянган төгрөгөөр тогтоосон бөгөөд тайлант онуудад ном хэвлэлийн зардалд 8.3 хувийг нь зарцуулахаар санал оруулжээ.

Хүснэгт №17: Ном, хэвлэлийн зардлыг төсвийн төсөл, батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэлтэй харьцуулсан харьцуулалт

Огноо	Төсвийн төсөлд өгсөн санал	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
2017	41.7	34.2	32.07	93.8
2018	43.5	16.4	14.7	89.6
2019	43.5	89.0	79.4	89.2


Эх үүсвэр: Аймгийн СТСХ-ийн тайлант онуудын төсвийн төсөл, батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэл

2019 оны төсвийн төсөлд ном хэвлэлийн зардалд 43.5 сая төгрөгөөр тооцсоныг 45.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж 89.0 сая төгрөгөөр баталсан байна.

A.3.1.5. Аймгийн БСУГ-аас 2016 онд БСШУЯ-д ирүүлсэн төсвийн төсөлд нэг сурагчид ногдох бусад хувьсах зардлыг орон нутгийн байршлаас нь хамааруулан 12.9-41.8 мянган төгрөгөөр тооцож төсөвлөсөн бөгөөд үүний 36.8%-ийг хичээл практикийн зардалд зарцуулахаар тооцоолжээ.

Бага, дунд, боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох бусад хувьсах зардлыг тооцохдоо 2016 оны төсвийг Засгийн газрын 2012 оны 94 дүгээр тогтоолоор, 2017 оноос хойш 2016 оны 242 дугаар тогтоолоор баталсан нормативыг баримтлан дараах зардлын төрлөөр жил бүр төлөвлөсөн байна.

Дүрслэл №09 Бусад хувьсах зардалд хичээл практик болон ном хэвлэлийн зардлын эзлэх хувь



Бусад хувьсах зардлын нормативыг 2012 оноос хойш 2016 онд шинэчлэн тогтоохдоо сумын бүрэн дунд боловсролын сургуулийн хувьсах зардлын хэмжээг өөрчлөөгүй, бусад сургуулийн нэг хүүхдэд ногдох бусад хувьсах зардлыг 1000 төгрөгөөр нэмэгдүүлж түүнээс хойш шинэчлэн тогтоогоогүй байгаа нь зах зээлийн үнийн өсөлттэй уялдахгүй байна.

A.3.2.1. Баянхонгор аймгийн ЕБС-ууд 2017-2019 онд нийт 69339.3 сая төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 69158.4 сая төгрөгийг зарцуулан 180.6 сая төгрөг хэмнэгдсэн байна.

Хүснэгт №18: Батлагдсан төсөвт орсон төлөвлөлт /мянган төгрөгөөр/

Огноо	Төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
2017 он	21057.3	21044.3	12.7
2018 он	21253.2	21227.97	25.2
2019 он	27024.8	26886.1	142.7

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс нь төсвийн санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу сар тутам олгодог ч хүүхэд өдрөөр хянаагүй байна. Энэ талаар аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэнтэй ярилцахад “хувийн сургуулиудын хүүхэд өдрийг хянадаг ч төрийн өмчийн сургуулиудын хүүхэд өдрийг хянах боломж байдаггүй” гэсэн тайлбарыг өгч байгаа нь боловсролын төсвийн мэргэжилтний орон тоо нь аймгийн СТСХ-т байхад хувьсах зардлын санхүүжилтийг хүүхэд өдрөөр хянаж олгохгүй Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор батлагдсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг сурагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлал”-ын 4.5¹² дахь заалтыг хэрэгжүүлэхгүй байна.

Хүснэгт №19: Батлагдсан төсвийн гүйцэтгэл /Сангийн яамны Э-тайлангаар/

Зардлын төрөл	2017 он		2018 он		2019 он	
	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Төлөвлөлт	Гүйцэтгэл
Нийт тогтмол зардал	2387.5	2378.3	3332.1	3329.3	3641.1	3588.2
Нийт хувьсах зардал	9385.8	9386.9	10303.5	10293.5	14054.2	14027.5
Үдийн цай	749.7	748.9	788.3	782.6	793.4	780.6
Дотуур байрны үйлчилгээ	2090.7	2088.0	1945.5	1942.9	2156.1	2125.6
Бусад зардал	6443.6	6442.1	4883.7	4879.2	6380.0	6367.2
Нийт зардал	21057.3	21044.2	21253.2	21227.5	27024.8	26889.1
Хүүхдийн тоо	15.9	16.1	16.3	16.1	16.9	17.0
Нэг хүүхдэд ногдох хувьсах зардал	0.6	0.6	0.6	0.6	0.8	0.8
Нэг хүүхдэд ногдох нийт зардал	1.1	1.1	1.1	1.1	1.4	1.4

Аудитын илрүүлэлт:

• Баянхонгор аймгийн төвд 2018-2019 оны хичээлийн жилээс үйл ажиллагаа явуулж буй “Баянхонгор-Олон улсын бага сургууль”-д төсвөөс олгох хувьсах зардлыг хүүхэд өдрийн гүйцэтгэлтэй тулган шалгахад 6.0 сая төгрөгийг илүү олгосон зөрчил илэрлээ. Иймд хувьсах зардалд илүү олгосон 6.0 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

¹² Хувьсах зардлын дундаж нормативын санхүүжилтийг аймаг, нийслэлийн боловсролын газар, нийслэл дүүргийн боловсролын хэлтэс сар бүр хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийн сар, улирлын хуваарьт батлагдсаны дагуу улирал тутам олгоно

A.3.2.2. Аймгийн ЕБС-удад ном сурах бичгийн зардалд 2017 онд 34.2 сая төгрөг батлагдаж 32.1 сая, 2018 онд 16.4 сая төгрөг батлагдаж 14.7 сая, 2019 онд 89.0 сая төгрөг батлагдаж, 79.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

ЕБС-удад батлагдсан дээрх зардал нь жил бүр санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан бөгөөд аудитын зөрчлийн нэгтгэлд дүн шинжилгээ хийхэд зориулалт бус зарцуулалт байхгүй байна.

A.3.2.3. Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт багшийн хөгжлийг дэмжих зорилгоор “Сайн багш” хөтөлбөрийг тусгажээ.

Энэхүү дэд хөтөлбөр нь багш нарын сургалтын процессыг шинжлэх ухааны үндэстэй жолоодох, суралцагчдын сурлага, хөгжил төлөвшлийн ахиц амжилтыг дэмжсэн, үйл ажиллагаагаа явуулах чадварыг дээшлүүлэх, үйл ажиллагаандаа хариуцлагатай, сэтгэлтэй хандах хандлагатай болгох зорилготой юм.

Хөтөлбөрийг аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, ИТХ-аар батлуулан, 2017 онд 128.3 сая төгрөг, 2019 онд 20.0 сая төгрөгийг орон нутгийн төсвийн ангилагдаагүй зардлаас зарцуулсан бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийг 2017 онд 80 хувь, 2018 онд 90, 2019 онд 88 хувьтай үнэлэгдсэн байна.

Хөтөлбөрийн хүрээнд орон нутгаас шийдвэрлэсэн хөрөнгө оруулалт нь ЕБС-ууд сургалтын хэрэглэгдэхүүн сайжрахад чухал дэмжлэг болсон бөгөөд сургалтын захирал, сургалтын менежер, багш

нарт сургалт зохион байгуулж, хэлэлцүүлэг хийн ахмад багш нараас туршлага судлах, илтгэл ур чадварын уралдаан зохион байгуулах, багш нарын мэргэжил ур чадварын түвшнийг ахиулан

Хүснэгт №20 Багш нарын түвшинг харуулбал:

Дүн	Багш нарын түвшин		Өөрчлөлт
	Хөтөлбөр хэрэгжиж эхлэх үед /2017 онд/	2019 онд	
A	16	17	1
B	60	75	15
C	107	123	16
D	257	282	25
F	516	308	(208)
Амжилт	46%	61.7%	15.7
Чанар	7.9%	11.4	3.8

ажилласны үр дүнд багш нарын мэдлэг ур чадварын амжилтыг 15,7 хувиар чанарыг 3,8 хувиар өсгөж нийт 265 багшийн мэдлэг ур чадварыг сайжруулсан ажилласнаас 208 багшийг хангалтгүйгээс хангалттай түвшинд хүргэж ажилласан байна.

A.3.2.4. Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор батлагдсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг сурагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлал”-ын 4.5¹³-д заасны дагуу аймгийн БСУГ-аас хяналт тавьж байгаа талаар тодруулахад аймгийн СТСХ-т төсвийн мэргэжилтний орон тоог бий

¹³ Хувьсах зардлын дундаж нормативын санхүүжилтийг аймаг, нийслэлийн боловсролын газар, нийслэл дүүргийн боловсролын хэлтэс сар бүр хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийн сар, улирлын хуваарьт батлагдсаны дагуу улирал тутам олгоно


болгосны дагуу манай байгууллага хянах нөхцөл бололцоо байхгүй болсон гэсэн хариу өгсөн.

Мөн аймгийн СТСХ нь сар улирал, жилийн батлагдсан хуваарийн дагуу санхүүжилтийг олгодог ч хувьсах зардал олголтод үр нөлөөтэй хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Харин боловсролын салбарын төсөв санхүү, эдийн засгийн шинжилгээ хариуцсан мэргэжилтэн албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 81 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар орон нутгийн БСУГ-ын харьяанд оруулан баталсан байгаа тул боловсролын төсвийн хяналтыг сайжруулах зорилгоор төсвийн мэргэжилтнийг аймгийн БСУГ-т шилжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх зөвлөмжийг БСШУЯ-д хүргүүлэх саналыг ҮАГ-ын ГАГ-ын багт хүргүүлэв.

A.3.2.5. ЕБС-ууд 2017-2019 онд үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардалд 2332.3 сая төгрөг батлагдсанаас 2312.8 сая төгрөг зарцуулж 19.5 сая төгрөг хэмнэгдэн буцаан төвлөрүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд үдийн цай хөтөлбөрт 2017 онд дунджаар 8401 хүүхдийн /1248167 хүүхэд өдөр/ 748.9 сая, 2018 онд дунджаар 8835 хүүхдийн /1305500 хүүхэд өдөр/ 783.3 сая, 2019 онд дунджаар 9127 хүүхдийн /1301000 хүүхэд өдөр/ 780.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.



Үдийн цайны зардлыг хүүхэд өдрөөр тооцон зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд жил бүр санхүүгийн тайлангийн аудит хийж хүүхэд өдрийн гүйцэтгэлийг тулган баталгаажуулсан байна.

A.3.2.6. Аймгийн ЕБС-уудад 2016-2019 онд БСШУЯ-аас хэрэгжүүлсэн “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд 636.2 сая, “Шинэ зууны боловсрол” төслийн хүрээнд 53.4 сая төгрөгийн төсөл хэрэгжиж, “Дэлхийн зөн” ОУБ-ын хөрөнгө оруулалтаар 367.2, НҮБ-ийн “Хүүхдийг ивээх сан”-ийн хөрөнгө оруулалтаар 78.3 сая, БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 349.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Хүснэгт №21: ЕБС-уудад хэрэгжсэн төсөл хөтөлбөр /мянган төгрөгөөр/

Огноо	Боловсролын шинэчлэл төсөл	Шинэ зуун боловсрол төсөл /БСШУЯ/	БСШУЯ-ны хөрөнгө оруулалт	Дэлхийн зөн ОУБ	НҮБ-ын хүүхдийг ивээх сан
2016	147.2	26.9	188.7	216.4	-
2017	145.0	26.5	97.1	150.7	35.3
2018	30.0	-	-	-	43.0
2019	314.0	-	63.7	-	-
Нийт	636.2	53.4	349.5	367.2	78.3

Аудитаар БСШУЯ-ны хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт болон гадаадын зээл тусламжаар санхүүжигдсэн хөрөнгийн хэрэгжилтийг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- Галуут сумын ерөнхий боловсролын сургууль нь 2019 онд 26.0 сая төгрөгийн төсөв бүхий Миний анги-миний гэр төслийг хэрэгжүүлснээс 5.9 сая төгрөгийн сургалт, зөвлөх үйлчилгээ, тайлант өдөрлөгийн арга хэмжээг хэрэгжүүлээгүй атлаа хөрөнгө бэлтгэсэн аж ахуйн нэгжийн дансанд шилжүүлсэн зэрэг зөрчил илэрч, аудитын явцад сургуулийн дансанд буцаан төвлөрүүлсэн.
- Эрдэнэмандал ахлах сургууль нь 2019 онд хэрэгжсэн төслийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэгслэгдэхүүнийг худалдан авсан ч хорио цээрийн улмаас төслийг 2020-2021 оны хичээлийн жилээс хэрэгжүүлж эхлээд байгаа ч явуулсан сургалт, үйл ажиллагааны зардлын 0.7 сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрч аудитын явцад сургуулийн дансанд буцаан төвлөрүүлсэн.

A.3.2.7. БСШУ-ы сайд, Сангийн сайдын 2008 оны 56/64 тоот хамтарсан тушаалаар “Сургууль, цэцэрлэг хөгжүүлэх сангийн үлгэрчилсэн дүрэм”-ийг баталсан ч үүний дагуу аймгийн хэмжээнд сургууль хөгжүүлэх сан байгуулсан төрийн өмчийн ЕБС байхгүй байна.

БҮЛЭГ 2. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ДОТООД БОЛОН ХӨНДЛӨНГИЙН ШАТНЫ ХЯНАЛТЫН ҮР ДҮН, БИЕЛЭЛТИЙГ ТУХАЙ БҮР ТООЦООГҮЙ НЬ СУРГАЛТЫН ЧАНАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ҮР НӨЛӨӨ ҮЗҮҮЛЭХГҮЙ БАЙНА.

Б.1. Ерөнхий боловсрол олгох үйлчилгээний үр дүнд салбарын яамнаас хийж буй чанарын үнэлгээг хязгаарлагдмал хүрээнд хийснээс сургалтын чанар бодитой үнэлэгдэхгүй, сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлийг тодорхойлохгүй байна.

Б.1.1.1. БШУЯ-ны сайдын 2014 оны А/240 тоот тушаалаар “Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр”, БСШУЯ-ны сайдын 2016 оны А/277 тоот тушаалаар “Бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөр”, 2016 оны А/302 тоот тушаалаар “Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр”-ийг тус баталж жил бүр салбарын яамнаас сургалтын төлөвлөгөө шинэчлэн баталсаны дагуу ЕБС-ууд сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөө боловсруулан баталж ажилласан байна.

Ерөнхий боловсролын сургуулиуд нь аудитад хамрагдах онуудын 2016-2018 онд БШУ-ны сайдын 2013 оны А/309 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын болон боловсролын чанарын үнэлгээний журам”, 2018-2019 оны хичээлийн жилээс БСШУС-ын сайдын 2018 оны А/425 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын дагуу сурагчийн үнэлгээ, дүнг үнэлж тооцсон байна.

Аудитаар ЕБС-ийн багш нар сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулалт, хичээлийн бэлтгэл хангалтыг иж бүрэн хийж сурагчдад эзэмшүүлбэл зохих мэдлэг, чадвар, дадлыг олгож байгаа эсэх талаар горим сорилыг аймгийн МХГ, БСУГ-ын

мэргэжилтнүүдээс хөндлөнгийн шинжээчээр татан оролцуулж нийт 115 багшийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, хичээлийн бэлтгэлийг түүвэрлэн гүйцэтгэв.

Аудитын илрүүлэлт:

- Галуутын Мандалын бага сургууль сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжийн дагуу хичээлийг төлөвлсөн гэх боловч тухайн ангийн хүүхдэд олгох агуулга, мэдлэг чадварыг бүрэн тусгаагүй цагийн төлөвлөлт дутуу, мөн сургалтад ашиглах гарын авлага, хэрэгжлэгдэхүүн, үнэлгээ судалгаа байхгүй байна. Багш нарын хичээлийн бэлтгэлд сургуулийн удирдлагаас тавих хяналт муу байна.
- Бөмбөгөр сумын ЕБС нь сургалтын менежерээс үр дүнг тооцох асуудал дутмаг.
- Өлзийт сумын ЕБС нь хичээлийн хэрэгжлэгдэхүүн, жишиг даалгавар, даалгаврын сан бүрдүүлэлт, явцын үнэлгээний арга зүй дутмаг,
- Шаргалжуут тосгоны ЕБС нь сурагчдын үнэлгээ, даалгаврын сан, жишиг даалгаварыг агуулгатаа дүйцүүлж, даалгаврын сан бүрдүүлээгүй зөвхөн түвшингээр үнэлсэн. Бага ангийн нэгж, ээлжит хичээлийн хөтөлбөр байхгүй.
- Жинст сумын ЕБС-ийн дунд ангийн зарим судлагдахууны багш нарын жилийн хөтөлбөр байхгүй.
- Баянлиг, Баян-Овоо сумын ЕБС-ийн зарим багш нар Сургалтын сайжруулсан хөтөлбөрийг хуулбарлан боловсруулалтгүй хөтөлбөр, төлөвлөлтийг хийж байна. Нэгж ээлжит хичээлийн хөтөлбөрийн чанарыг сайжруулах, зорилго зорилт, үнэлгээ зэргийг тодорхой тусгаж төлөвлөдөггүй, сургалтын хэрэгжлэгдэхүүний сан бүрдүүлж ажиллаагүй байна.
- Баянговь сумын ЕБС хөтөлбөрийн бүтцэд зорилго, арга зүй, үнэлгээ байхгүй, сургалтын хэрэгжлэгдэхүүн, даалгаврын сан бүрдүүлж ажиллаагүй.

БСШУ-ны сайд, НХХС, Сангийн сайдын 2007 оны 307/91/237 тоот хамтарсан тушаалаар баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам”-ын 2.11¹⁴-д

Дүрслэл №11. Багшийн ажлын цагийн норматив



багшийн сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг сайжруулах, стандартыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд 3 цаг зарцуулахаар тогтоосон байхад зарим багш нар нь хөтөлбөр, төлөвлөгөөг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглахгүй зөвхөн үзүүлэх, тооцуулах төдийгөөр ашиглаж байгаа нь цаашид багш нар багаар ажиллах, сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжийг баяжилт хийн үйл ажиллагаанд ашиглах, хэрэглээг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Иймд ЕБС-ийн захирал, сургалтын менежер нар нь багшийн төлөвлөгөө хөтөлбөр, хичээлийн бэлтгэл хангалтад тавих хяналтыг сайжруулж, үр дүнг тогтмол үнэлж хэвшүүлэхэд нэгдсэн арга зүйн удирдлагаар хангаж ажиллах зөвлөмжийг аймгийн БСУГ-т хүргүүлэв.

Бага боловсролын буюу 5-р ангийн 2017-2018, 2018-2019 оны хичээлийн жилийн улсын шалгалтын дүнг хичээл тус бүрээр харьцуулахад аймгийн дүнгээр нийт 6 хувийн өсөлт гарсан байгаа хэдий ч Бууцагаан сумын Баянбүрдийн бага сургууль,

¹⁴ Сургуулийн багш долоо хоногт 34 цагтай тэнцэх стандартыг хэрэгжүүлэх ажил, 6 цагтай тэнцэх бусад ажлыг тус тус гүйцэтгэнэ. Стандартыг хэрэгжүүлэх ажилд ногдох 34 цагийн 19 цаг нь хичээл заах цагт зориулагдана.

Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулиуд хичээл тус бүр дээр өмнөх оноосоо үнэлгээ нь буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт №22. Бага боловсролын улсын шалгалтын дүнгийн нэгтгэл

Сургууль	Математик			Монгол хэл			Хүн ба байгаль		
Хичээлийн жил	2017-2018	2018-2019	(+, -)	2017-2018	2018-2019	(+, -)	2017-2018	2018-2019	(+, -)
Баацагаан	48%	81%	▲33%	47%	80%	▲32.6%	63.9%	79.4%	▲15.5%
Баянбулаг	69%	74%	▲5%	83%	74%	▼8.3%	75.4%	83.1%	▲7.7%
Баянбүрдний бага сургууль	81%	80%	▼1%	87%	81%	▼6.3%	83.3%	80.0%	▼3.3%
Баянговь	59%	55%	▼4%	76%	68%	▼7.5%	65.1%	72.7%	▲7.6%
Баянлиг	45%	74%	▲29%	55%	81%	▲25.7%	78.8%	90.9%	▲12.1%
Баян-ойт	92%	91%	▼1%	92%	93%	▲0.4%	93.2%	83.7%	▼9.4%
Баян-Өндөр	61%	66%	▲5%	68%	72%	▲4.0%	68.7%	74.3%	▲5.6%
Баянцагаан	53%	74%	▲22%	70%	84%	▲14.4%	68.1%	83.2%	▲15.1%
Богд	51%	67%	▲15%	67%	77%	▲10.3%	62.7%	74.4%	▲11.7%
Бөмбөгөр	72%	80%	▲8%	71%	84%	▲12.3%	75.4%	84.3%	▲8.9%
Бууцагаан	72%	78%	▲6%	81%	83%	▲2.2%	74.8%	81.9%	▲7.1%
Галуут	60%	56%	▼3%	67%	75%	▲8.2%	68.7%	71.8%	▲3.1%
Гурванбулаг	73%	77%	▲5%	80%	77%	▼3.1%	77.4%	74.4%	▼3.0%
Жаргалант	85%	81%	▼4%	85%	80%	▼5.3%	88.2%	80.1%	▼8.1%
Жинст	73%	81%	▲8%	73%	87%	▲13.5%	76.5%	80.4%	▲3.9%
Заг	74%	76%	▲3%	80%	78%	▼1.9%	69.4%	78.9%	▲9.4%
Мандалын бага сургууль	63%	62%	▼1%	42%	67%	▲24.7%	64.0%	67.7%	▲3.7%
Номгон	57%	67%	▲10%	77%	80%	▲2.9%	78.2%	73.7%	▼4.5%
Номундалай	54%	72%	▲18%	63%	85%	▲22.8%	63.9%	79.4%	▲15.5%
Өлзийт	68%	66%	▼1%	69%	79%	▲10.8%	77.0%	86.6%	▲9.5%
Соогоо сейко	67%	74%	▲7%	62%	82%	▲20.1%	72.0%	72.7%	▲0.7%
Хүрээмарал	76%	77%	▲0%	75%	74%	▼1.4%	80.2%	79.0%	▼1.1%
Шаргалжуут	57%	60%	▲3%	62%	61%	▼1.3%	69.4%	64.0%	▼5.4%
Шинэжинст	61%	67%	▲7%	66%	65%	▼1.0%	72.6%	68.0%	▼4.5%
Эрдэм	49%	42%	▼7%	46%	64%	▲18.2%	62.3%	72.8%	▲10.5%
Эрдэнэмандал	61%	64%	▲2%	48%	77%	▲29.1%	62.2%	66.0%	▲3.7%
Эрдэнэцогт	86%	78%	▼8%	61%	81%	▲19.9%	87.0%	82.0%	▼5.0%
НИЙТ ДУНДАЖ	65%	71%	▲6%	69%	77%	▲9%	73%	77%	▲4%

Эх сурвалж: УАГ-аас ирүүлсэн улсын шалгалтын дүнгийн нэгтгэл

Бүрэн дунд боловсролын буюу 12-р ангийн 2017-2018, 2018-2019 оны хичээлийн жилийн улсын шалгалтын дүнг хичээл тус бүрээр харьцуулахад аймгийн дүнгээр нийт 2 хувиар буурсан ба аймгийн төвийн Эрдэм ахлах сургууль, Жаргалант, Баянцагаан, Өлзийт, Бууцагаан, Богд, Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургуулиудын үнэлгээ өмнөх оноос буурсан нь нөлөөлсөн байна.

Хүснэгт №23. Ахлах ангийн улсын шалгалтын дүнгийн нэгтгэл

Сургууль	Англи хэл		Биологи		Газарзүй		Математик		Монгол хэл		Ийгэм судла		Орос хэл		Физик		Хими		Нийт дундаж		(+, -)
Хичээлийн жил	2017-2018	2018-2019	2017-2018	2018-2019	2017-2018	2018-2019	2017-2018	2018-2019	2017-2018	2018-2019	2017-2018	2018-2019	2017-2018	2018-2019	2017-2018	2018-2019	2017-2018	2018-2019	2017-2018	2018-2019	(+, -)
Соогоо сейко	85%						80%		84%		87%				88%		91%		86%		
Номундалай	87%	87%	85%				81%	91%	83%	84%	88%	87%			84%	78%	88%	10%	85%	73%	▲12%
Баацагаан	80%	67%	82%	78%	76%		82%	8%	78%	73%	94%	68%			9%		86%		73%	59%	▲14%
Жаргалант	8%	83%	87%	89%	89%	84%	77%	8%	70%	83%	86%	83%							70%	72%	▼2%
Баянцагаан	76%	80%	9%	86%	83%		7%	79%	79%	9%	9%	8%			89%				50%	53%	▼2%
Эрдэм	9%	83%	73%	91%	9%		72%	74%	78%	75%	10%	76%			8%	86%	90%	77%	43%	80%	▼37%
Өлзийт	77%		88%		8%		8%		77%		79%				74%		90%		62%		
Бууцагаан	76%	84%	8%		78%		73%	86%	84%	85%	80%	83%	79%		82%	92%	88%		72%	86%	▼14%
Богд	74%	70%	68%	92%			8%	7%	75%	74%	78%	65%			93%	79%	9%		58%	64%	▼6%
Эрдэнэцогт	83%	81%	73%	79%			75%	86%	67%	79%	82%	82%			83%	78%			77%	81%	▼4%
Номгон	79%	80%	76%	45%	82%		72%	86%	78%	76%	79%	67%			71%	56%	79%	83%	77%	70%	▲7%
Галуут	78%	75%	7%				69%	8%	69%	80%	76%	70%							60%	58%	▲2%
Баянлиг	74%	67%	68%	6%			69%	68%	78%	85%	73%	8%				68%			72%	50%	▲22%
Эрдэнэмандал	73%	44%	56%	57%			67%	7%	75%	50%	69%	55%		54%	58%	46%	72%		67%	45%	▲22%
НИЙТ ДУНДАЖ																			68%	66%	▼2%

Эх сурвалж: УАГ-аас ирүүлсэн улсын шалгалтын дүнгийн нэгтгэл

ЕБС-ийн ахлах анги төгссөн цаашид их, дээд сургууль, коллежид үргэлжлүүлэн суралцах хүсэлтэй суралцагчийн мэдлэг, чадварын түвшнийг тогтоох зорилгоор Математик, монгол хэл, нийгэм судлал, англи хэл, орос хэл, газарзүй, физик, биологи, хими, монголын түүх гэсэн арван хичээлээр ЭЕШ-ийг БҮТ-өөс улсын хэмжээнд зохион байгуулан авч байна. Элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээгээр 2016-2017 хичээлийн жилд аймгийн дундаж улсын хэмжээнд 6 дугаарт эрэмбэлэгдэж байсан бол 2017-2018 оны хичээлийн жилд 21 дүгээрт орж 15 байраар буурсан бол 2018-2019 оны хичээлийн жилд 19 дүгээрт эрэмбэлэгдсэн байна.

Хүснэгт №24. Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгийн нэгтгэл

Сургуулийн нэр	Үзүүлэлт	2016-2017	2017-2018	Өсөлт бууралт	2018-2019	Өсөлт бууралт
Баацагаан	Дундаж дүн	29.2%	34.7%	▲5.5%	32.4%	▼2.3%
	Эрэмбэ	12	12	0	6	▲6
Өлзийт	Дундаж дүн	44.2%	42.6%	▼1.6%		
	Эрэмбэ	3	1	▲2		
Галуут	Дундаж дүн	27.7%	21.9%	▼5.9%	27.9%	▲6.0%
	Эрэмбэ	13	13	0	12	▲1
Баянлиг	Дундаж дүн	39.0%	37.5%	▼1.5%	41.3%	▲3.8%
	Эрэмбэ	6	4	▲2	2	▲2
Баянцагаан	Дундаж дүн	37.6%	34.6%	▼2.9%	26.4%	▼8.3%
	Эрэмбэ	8	9	▼1	9	0
Богд	Дундаж дүн	41.3%	32.9%	▼8.4%	37.8%	▲4.9%
	Эрэмбэ	5	8	▼3	3	▲5
Жаргалант	Дундаж дүн	34.7%	36.6%	▲1.9%	35.8%	▼0.8%
	Эрэмбэ	9	3	▲6	7	▼4
Бууцагаан	Дундаж дүн	34.2%	33.5%	▼0.7%	33.9%	▲0.4%
	Эрэмбэ	14	11	▲3	8	▲3
Эрдэнэцогт	Дундаж дүн	45.8%	37.8%	▼8.0%	34.3%	▼3.4%
	Эрэмбэ	1	6	▼5	11	▼5
Номгон	Дундаж дүн	36.7%	36.9%	▲0.2%	30.7%	▼6.2%
	Эрэмбэ	7	2	▲5	5	▼3
Номундалай	Дундаж дүн	35.8%	32.7%	▼3.1%	39.6%	▲6.9%
	Эрэмбэ	10	10	0	1	▲9
Соого сейко	Дундаж дүн	46.9%	37.0%	▼9.9%		
	Эрэмбэ	2	7	▼5		
Эрдэм	Дундаж дүн	40.6%	40.1%	▼0.5%	31.9%	▼8.2%
	Эрэмбэ	4	5	▼1	10	▼5
Эрдэнэмандал	Дундаж дүн	32.0%	27.7%	▼4.3%	39.2%	▲11.5%
	Эрэмбэ	11	14	▼3	4	▲10
АЙМГИЙН ДУНДАЖ	Дундаж дүн	37.6%	34.7%	▼2.8%	34.3%	▼0.5%
	Эрэмбэ	6	21	▼15	19	▲2

Эх сурвалж: Аймгийн БСУГ-аас ирүүлсэн ЭЕШ-ын дүнгийн нэгтгэл

ЭЕШ-ийн үнэлгээ 2017-2018 оны хичээлийн жилд буурсан шалтгаан, үнэлгээ буурсан сургуулийн захирлуудад хариуцлага тооцож байгаа эсэх талаар БСУГ-ын Сургалт, арга зүйн хэлтсийн даргаас тодруулахад “Аймгийн Засаг дарга, БСУГ-ын даргын сургуулийн захиралтай байгуулсан гуравласан гэрээнд бүх шалгалт, үнэлгээнд 60-с дээш хувиар үнэлэгдэх гэсэн шалгуур оруулсан бөгөөд тус шалгуурыг хангахгүй байгаа захирлуудад үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгохгүй, хариуцлага тооцох бодлого барьж байгаа ч бусад хариуцлага тооцсон захирал байхгүй. ЭЕШ-ийн үнэлгээ 2017-2018 онд 15 байраар буурсан нь 2016-2017 оны хичээлийн жилд сайн хүүхдээ сайн болгоё гэсэн зорилт тавьж зөвхөн ЭЕШ-д хамрагдах багш нарын дунд болзолт уралдаан явуулж мөнгөн урамшуулал олгох хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд улсын хэмжээнд 6 дугаар байрт орж байсан ч дараагийн жилээс багш нараас босго үзүүлэлтийг бууруулах санал гарснаар үргэлжлүүлж хэрэгжүүлээгүйтэй холбоотой” гэсэн тайлбар өгч байна. Мөн ЭЕШ-ийн дүнгээр улсын дунджаас доогуур байр эзэлж байгаад бас нэг нөлөөлж буй хүчин зүйл нь бусад аймгуудын хувьд ЭЕШ-д орох хүүхдүүдээс ЭЕШ-ийн өмнө нь сургуулийн зүгээс сорил шалгалт авч босго оноо тогтоогоод босго онооноос дээгүүр үнэлэгдсэн хүүхдүүдээ ЭЕШ-д оруулдаг гэсэн тайлбар өгсөн ба энэ талаар Дорнод, Өвөрхангай, Завхан аймгуудын аудитын багаас тодруулахад тус асуудлыг үгүйсгэж байгаа нь дээрх тайлбар үндэслэлтэй эсэхийг аудитаар нотлох боломжгүй байна.

Цаашид сурлагын чанар амжилтын ахиц гаргахгүй байгаа сургуулийн захирлуудад хариуцлагын тогтолцоог бий болгох бодлого хэрэгжүүлж, сургуулийн захирал шинээр томилохдоо “Сургууль хөгжүүлэх менежментийн төлөвлөгөө”-г

шалгаруулах нээлттэй уралдаант сонгон шалгаруулалт явуулж хүрэх түвшнийг тодорхойлуулан үнэлж сонгох зөвлөмжийг аймгийн БСУГ-т хүргүүлэв.

2016-2017 оны хичээлийн жилд Өлзийт, Богд, Эрдэнэцогт сумдын сургууль аймгийн төвийн Соогоо сейкео сургууль, 2017-2018 оны хичээлийн жилд Өлзийт сумын сургуулийн дундаж үнэлгээ улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн бол 2018-2019 оны хичээлийн жилд улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн сургууль байхгүй байна. Аудитад хамрагдсан онуудад Өлзийт сумын ЕБС нь 2 удаа 12 дугаар анги төгсгөж ЭЕШ өгсөн ба улсын дунджаас дээгүүр үнэлгээ авсан талаар сургуулийн захирлаас тодруулахад *“багш нарын хичээл заах ур чадвар сайн, өдөр тутам давтлага өгч ажилладаг, эцэг эхийн оролцоо сайн, хүүхдийн хичээл сургалтад байнга хяналт тавьдаг, сурагчийн хичээл сурталтандаа оролцох идэвх оролцоо, хандлага сайн байдаг нь сургалтын чанарт сайн нөлөө үзүүлж байдаг”* гэсэн тайлбарыг өгч байна.

Цаашид сурлагын чанар амжилтын тогтмол сайн үзүүлэлт гаргаж байгаа сургуулиудын сайн туршлагыг бусад сургуулиудад түгээх, туршлага солилцуулах үйл ажиллагааг идэвхжүүлж аймгийн хэмжээний сурлагын чанар амжилтын түвшнийг нэмэгдүүлэхэд нэгдсэн бодлого арга зүй, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах зөвлөмжийг аймгийн БСУГ-т хүргүүлэв.

Б.1.1.2. Аудитаар сургуулийн сурагчдын цүнхэндээ авч явдаг сурах бичгийн талаар тодруулахад аймгийн ерөнхий боловсролын зарим сургуулиуд салбарын яамны баталсан албан сурах бичгээс гадна 1-5 дугаар ангид О.Аззаяа зохиогчийн “Монгол хэл-Математикийн дасгал ажлын ном” /17х24 хэмжээтэй 160 граммтай/ , “Сэтгэх чадварын хичээл буюу IQ-ийн ном” /14х21 хэмжээтэй 35 граммтай/ гэсэн номуудыг нэмэлтээр хэрэглэж байгаа бөгөөд байнга цүнхэндээ авч явдаг, 1-2-р ангид “Асуудаг” номыг /20х14 хэмжээтэй 190 граммтай/ ангидаа хэрэглэдэг байна. Харин дунд ахлах ангид сурагчдын сонгон судлах, гүнзгийрүүлэн судалж байгаа хичээл тус бүрт сургууль тус бүр өөрсдийн сургалтын хөтөлбөртэй уялдуулан нэмэлт сурах бичгийг ашиглуулж байна.

Зураг №1 Хүүхдийн цүнхний жингийн талаар өгсөн зөвлөмж



Ерөнхий боловсролын бодлогын газрын гаргасан зөвлөмж	
хичээлийн хэрэгсэл	хэрэгслийн жин
Дасгал ажлын ном	500-1100 гр
Ном тогтоогч (том, жижиг)	300-500 гр
Хөгжмийн хичээлийн бишгүүр (ууттай)	300 гр
Зургийн болон бусад хэрэгсэл	100-160 гр
Үдийн цайны хэрэгсэл (Савтай, ус ундаа)	100-120 г

Сурагчийн цүнхний жингийн хувьд мөрдөх стандарт, хуульчилсан нарийн зохицуулалт байхгүй ба БСШУСЯ-наас сургуулийн удирдлага, багш, эцэг, эх, асран хамгаалагч нарт 2018 оны 8 дугаар сард ерөнхий боловсролын сургуулийн цүнхний жингийн тухай

зөвлөмж хүргүүлсэн байна.

Тус зөвлөмжид сургуулийн удирдлага багш нарт сурагчийн биеийн жинг хэмжиж, сурагч цүнхний нийт жин нь хүүхдийнхээ биеийн жингийн 10 хувиас хэтрэхгүй байхад хяналт тавих, сурагчдын өөрсдийн жинд тохируулан цүнхний жингийн норм хэмжээг анги бүр гарган мөрдөх ажлыг зохион байгуулах, тухайн өдөр орох хичээлийн хуваарийн дагуу сурах бичиг, дэвтэр, гарын авлага гэх мэт зүйлсийг ялгаж буйд хяналт тавих ажлыг зохион байгуулах, сурагчдад боломжтой бол аль болох нимгэн дэвтэр ашиглахыг дэмжих, хичээлд ач холбогдол багатай нэмэлт хэрэгслээр сурагчдын цүнхний жинг нэмэгдүүлэхгүй байх гэсэн зөвлөмжүүдийг өгсөн байгаа ч зөвлөмжийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ дутмаг байна.

Тухайлбал: Аудитаар хүүхдийн цүнхний жинг жинлэж үзэхэд 1-р анги сурагчийн цүнх 1.5-4.8 кг, 2-р ангийн сурагчийн цүнх 2.1-3.9 кг, 3-р ангийн сурагчийн цүнх 2.3-3.7 кг, 4-р ангийн сурагчийн цүнх 2.0-7.1 кг, 5-р ангийн сурагчийн цүнх 2.7-5.6 кг, цүнх дангаараа 725-868 гр байгаа ба зарим сургуулийн сурагчид хичээлийн хуваарийн дагуу сурах бичгийг ялгаж ирэхгүй бүгдийг нь цүнхэлж ирсэн байна.

Иймд цаашид БШУ-ы сайдын 2013 оны А/315 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэлийн Боловсролын газрын үлгэрчилсэн журам”-ын 2.1.1¹⁵-д заасны дагуу ЕБС-ууд хүүхдийн цүнхий жингийн талаар БСШУСЯ-аас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг аймгийн БСУГ-т хүргүүлэв.

Б.1.1.3. Баянхонгор аймагт олон улсын сургалттай төрийн болон хувийн өмчийн сургууль байхгүй.

Б.1.2.1. Боловсролын тухай хуулийн 17¹ дүгээр зүйлийн 17^{1.1}¹⁶-т заасны дагуу

Хүснэгт №25. 2017 оны чанарын үнэлгээний судалгааны дүн

Сургуулийн нэр		Улсын дундаж	Номун далай	Номгон	Сайн-оюут
5-р анги	Математик	48.6%	42.5%	45.7%	53.1%
	Монгол хэл	36.6%	31.2%	34.2%	38.6%
	Байгаль шинжлэл	49.2%	45.4%	44.6%	58.6%
9-р анги	Математик	27.6%	22.0%	25.9%	24.4%
	Монгол хэл	47.4%	47.9%	52.8%	54.7%
	Байгалийн ухаан	30.7%	23.1%	28.0%	38.9%
	Нийгмийн ухаан	38.5%	34.8%	34.2%	38.0%
12-р анги	Математик	35.5%	16.6%	18.2%	34.0%
	Монгол хэл	35.5%	42.6%	38.3%	36.9%
	Нийгмийн ухаан	35.5%			43.9%
	Англи хэл	35.5%	26.8%	33.8%	64.2%
	Орос хэл	35.5%	26.3%	28.0%	39.1%
	Газар зүй	35.5%			46.3%
	Физик	35.5%		24.6%	
	Биологи	35.5%	28.2%	22.4%	
	Хими	35.5%	25.9%		
НИЙТ ДУНДАЖ		37.4%	31.8%	33.1%	43.9%

Эх сурвалж: БУТ-ийн чанарын үнэлгээний судалгааны нэгтгэл

Боловсролын үнэлгээний төв нь 2014 оноос эхлэн жил бүр тухайн цаг үед үндэсний хэмжээнд хэрэгжиж буй хөтөлбөрийн хэрэгжилт, чанар үр дүнг хэмжин үнэлэх, сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тодорхойлох, сургалтын хөтөлбөрийн үр өгөөж, алдаа оноог нягтлан үзэх зорилгоор боловсролын чанарын үнэлгээний судалгааг улсын хэмжээнд түүврээр зохион байгуулсан байна.

¹⁵ Боловсролын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, шийдвэрийг байгууллага, олон нийтэд сурталчлан таниулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тэдгээрийг сургууль, цэцэрлэгт хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүй, удирдлагын дэмжлэг үзүүлэх, тайлагнах;

¹⁶ Боловсролын үнэлгээний байгууллага бүх шатны боловсролын чанарт үнэлгээ, судалгаа хийх, сургалт зохион байгуулах, дээд боловсролын хөтөлбөрт элсэгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтыг үндэсний түвшинд хариуцан зохион байгуулах чиг үүрэг бүхий хуулийн этгээд мөн.

БҮТ-өөс 2017 онд улсын хэмжээнд түүвэрлэн хийсэн чанарын үнэлгээний шалгалтад “Номундалай”, “Номгон”, Өлзийт сумын ЕБС гэсэн 3 сургуулийн 5, 9, 12 дугаар ангиуд хамрагдсанаас Өлзийт сумын ЕБС нь улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн бол аймгийн төвийн “Номундалай”, “Номгон” ахлах сургуулиудын үнэлгээ улсын дунджид хүрээгүй байна.

2018 онд улсын хэмжээнд түүвэрлэн хийсэн чанарын үнэлгээний шалгалтад аймгийн төвийн “Номундалай”, “Эрдэм” сургууль, Бууцагаан сумын ерөнхий боловсролын сургуулиудын 5, 9, 12 дугаар ангиуд хамрагдсан ба 5, 12-р ангийн дүнг сургууль хичээл тус бүрээр нэгтгэн гаргасан байгаа ч 9-р ангийн шалгалтын дүнг сургууль, хичээлээр нэгтгэн гаргаагүй байна. Тус үнэлгээнд хамрагдсан сургуулиудын дундаж үнэлгээ нь улсын дунджаас доогуур үнэлэгдсэн байгаа ба хичээл тус бүрээр авч үзвэл “Номун далай” цогцолбор сургуулийн Монгол хэл, Математикийн хичээл, “Эрдэм” ахлах сургуулийн Математикийн хичээлийн үнэлгээ нь улсын дунджаас дээгүүр үнэлэгдэж бусад хичээлүүдийн дүн бүгд улсын дунджаас доогуур үнэлэгджээ.

Хүснэгт №26. 2018 оны чанарын үнэлгээний судалгааны дүн

№	Сургуулийн нэр	5-р анги			12-р анги								НИЙТ ДУНДАЖ
		Математик	Монгол хэл	Байгаль шинжлэл	Математик	Монгол хэл	Англи хэл	Хими	Физик	Биологи	Газар зүй	Нийгэм	
	Улсын дундаж	40.0%	40.0%	40.0%	27.5%	53.2%	46.0%	25.6%	23.1%	32.2%	42.5%	42.5%	37.5%
7	Номун далай	27.5%	25.5%	36.8%	20.9%	54.1%	37.3%	28.2%	16.3%	21.6%	27.3%	32.9%	29.9%
8	Эрдэм	21.1%	18.8%	32.4%	41.0%	47.8%	32.2%	14.5%	13.4%	14.4%	23.8%	37.8%	27.0%
9	Бууцагаан	22.0%	30.7%	33.5%	8.8%	53.0%	26.1%	20.0%	21.0%	10.8%	32.3%	32.0%	26.4%

2019 онд улсын хэмжээнд түүвэрлэн хийсэн чанарын үнэлгээний шалгалтад “Номундалай”, “Соогоо сейкео”, Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулиудын 3, 10 дугаар ангиуд хамрагдаж “Номундалай”, “Соогоо сейкео” сургуулиудын нийт дундаж нь улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн бол Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн үнэлгээ улсын дунджид хүрээгүй байна.

Хүснэгт №27. 2019 оны чанарын үнэлгээний судалгааны дүн

№	Сургуулийн нэр	3-р анги				10-р анги					НИЙТ ДУНДАЖ
		Математик	Монгол хэл	Хүн орчин	Хөгжим	Математик /заавал/	Математик /сонгон/	Монгол хэл	Газар зүй	Биологи	
	Улсын дундаж	53.3%	37.4%	68.9%	39.6%	28.4%	26.3%	49.6%	29.8%	23.6%	39.7%
7	Баацагаан	36.7%	27.6%	65.8%			9.6%	61.4%	19.0%		36.7%
8	Номун далай	66.7%	38.1%	74.6%	44.4%	49.8%	59.6%	56.5%	28.4%	36.4%	50.5%
9	Соогоо сейкео	56.9%	35.6%	84.2%	41.1%	25.0%	24.4%	45.2%	30.8%	34.1%	41.9%

Хүснэгт №28. 2019 оны бүх 9-р ангийн чанарын үнэлгээний судалгааны дүн

№	Сургуулийн нэр	Ерөнхий дундаж	Шалгалтын агуулга /гүйцэтгэлийн хувиар/			
			Математик	Монгол хэл	Англи хэл	Физик
1	Номун далай АС	48.2%	53.0%	58.4%	34.8%	31.5%
2	Бөмбөгөр сумын ЕБС	45.0%	39.9%	54.8%	40.7%	39.9%
3	Хүрээмарал сумын ЕБС	44.9%	49.1%	57.2%	20.7%	35.0%
4	Богд сумын БДС	44.4%	46.7%	60.4%	25.0%	27.3%
5	Шинэжинст сумын ДС	42.8%	45.5%	63.1%	16.8%	23.0%
6	Соого сейкео АС	40.6%	35.2%	57.9%	27.1%	30.8%
7	Эрдэм сургууль	39.8%	39.1%	48.6%	37.4%	26.3%
8	Жинст сумын ДС	38.4%	32.4%	49.2%	43.6%	26.0%
9	Баян-Өндөр сумын ДС	35.5%	38.6%	48.6%	16.4%	22.2%
10	Номгон АС	35.3%	29.0%	53.8%	21.7%	24.2%
11	Эрдэнэмандал сумын АС	35.0%	36.1%	47.8%	18.6%	23.3%
12	Жаргалант сумын АС	34.7%	34.9%	51.8%	17.3%	17.3%
13	Шаргалжуут тосгоны ДС	34.1%	31.5%	46.8%	26.5%	21.8%
14	Эрдэнэцогт сумын БДС	34.0%	21.8%	54.2%	29.8%	20.9%
15	Баацагаан сумын АС	33.9%	41.2%	40.9%	18.5%	20.4%
16	Баянцагаан сумын БДС	33.8%	35.6%	48.3%	16.2%	18.1%
17	Галуут сумын ЕБС	33.4%	27.4%	50.0%	26.2%	19.4%
18	Баянговь сумын ЕБС	33.0%	28.0%	44.1%	33.3%	21.0%
19	Баянбулаг сумын ЕБС	32.9%	33.5%	45.8%	18.9%	20.8%
20	Өлзийт сумын ЕБС	32.3%	28.3%	43.5%	22.7%	27.6%
21	Баян-Овоо сумын ДС	32.1%	31.9%	33.8%	42.7%	18.5%
22	Баянлиг сумын БДС	31.4%	20.3%	47.7%	28.9%	23.5%
23	Бууцагаан сумын АС	31.4%	19.9%	55.6%	15.0%	21.1%
24	Заг сумын ДС	30.5%	23.6%	45.8%	19.2%	24.8%
25	Гурванбулаг сумын ЕБС	27.7%	24.5%	40.4%	11.4%	25.2%

Мөн тус онд бүх сургуулийн 9-р ангиас математик, монгол хэл, англи хэл, физик гэсэн 4 хичээлээр чанарын үнэлгээний шалгалт авсан ба Баянхонгор аймгийн 25 сургуулиас 11 сургууль улсын дунджаас дээгүүр үнэлэгдэж 14 сургууль нь улсын дунджаас доогуур үнэлэгдсэн байна.

Дээрх чанарын үнэлгээний шалгалтын аймгийн дундаж дүнг улсын дундажтай харьцуулахад 2019 оны бага, суурь боловсролын үнэлгээ улсын дунджаас дээгүүр үнэлэгдэж байсан ба мөн тус онд бүх шатны боловсролын чанарын үнэлгээний шалгалт нь өмнөх онуудаас өссөн үзүүлэлт гарсан байна.

Энэ талаар аймгийн БСУГ-ын Сургалт, арга зүйн хэлтсийн даргаас тодруулахад: “Манай газрын хувьд өмнөх онуудад чанарын үнэлгээний дүн улсын дунджаас доогуур байсан тул 2019 онд улсын дунджаас дээгүүр үнэлэгдье гэдэг зорилт тавьж ажилласан. Үүний үр дүнд тодорхой амжилт гарсан. Мөн 2017, 2018 онуудад аймгаас нийтдээ 3 сургууль л сонгоод тухай сургуулийн бага, суурь, ахлахын нэг нэг анги сонгоод шалгалт авч байсан. Харин 2019 онд бүх 9 дүгээр ангийн бүх хүүхдийг хамруулсан нь бас нэг шалтгаан болсон, бусад ангийн хувьд сонгогдсон гурван сургуулиас өөр сургууль сонгогдсон ч ойролцоо үнэлгээтэй байх байсан. Сургууль, багш нарын сайн ололтой зүйлийг бусдад нь суралцуулах нэвтрүүлэхэд чиглэсэн “Туршлагын эмхэтгэл” гаргах, бүсийн арга хэмжээ зохион байгуулж багш нарын туршлага солилцох арга хэмжээг явуулдаг байсан ч харин энэ арга хэмжээг сүүлийн 2 жилд зохион байгуулаагүй.. Цаашид 2019 оны үнэлгээг бууруулахгүй гэсэн зорилт тавиад ажиллаж байгаа,” гэсэн тайлбар өгч байгаа нь цаашид чанарын үнэлгээний шалгалтыг илүү өргөн цар хүрээтэй авснаар бодитой үр дүн гарах боломжтой гэдгийг харуулж байна.


Хүснэгт №29. Чанарын үнэлгээний дүнгийн нэгтгэл

Үзүүлэлт	Улсын дундаж			Баянхонгор аймгийн үнэлгээ			Өсөлт бууралт	
	2017 он	2018 он	2019 он	2017 он	2018 он	2019 он	2018 он	2019 он
Бага	44.8%	40.0%	37.4%	42.5%	27.6%	55.2%	▼14.9%	▲27.6%
Суурь	36.1%	31.0%	35.0%	35.6%	24.8%	37.8%	▼10.8%	▲13.0%
Ахлах	35.5%	36.6%	49.6%	33.4%	27.8%	42.1%	▼5.6%	▲14.3%

Б.1.2.2. Аудитаар ЕБС-ийн багш, ажилчдаас цахимаар авсан санал асуулгад

Дүрслэл №12. Санал асуулгын дүн

Сургуулийн хэмжээнд сургалтын чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, үнэлэх ажил хийгддэг үү?



■ Огт хариулаагүй ■ Тийм ■ Тодорхой хэмжээнд хийгдэж эхэлсэн ■ Үгүй

“Сургуулийн сурагчдын сурлагын чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийг нэрлэнэ үү” гэсэн асуултад 7 төрлийн давхардсан тоогоор 630 санал ирүүлсэн ба үүнээс 31 хувь нь “Гэр бүлийн орчин /эцэг эхийн оролцоо, боловсролын түвшин, өрхийн орлого/” 26 хувь нь “Сургалтын хөтөлбөрийн тогтворгүй байдал”, 14 хувь нь “Сургууль, анги танхимын орчин /нэг ангид ногдох хүүхдийн тоо, сургуулийн орчин зэрэг/, сургалтын чанарт гол нөлөөг үзүүлж байгаа гэсэн хариултыг өгсөн байна.

Аудитаар аймгийн ЕБС-уудийн захирал, менежер, багш нараар сургалтын чанарт сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг үнэлүүлэхэд дараах хүчин зүйлсийг голлох нөлөө үзүүлж байгаа гэж тодорхойлж байна. Үүнд

- “сурагчдын эцэг эхийн оролцоо бага”,
- “салбар яамнаас гаргаж байгаа хөтөлбөр тогтворгүй байгаагаас багш нар арга зүй сууж төлөвшихэд цаг хугацааны хувьд хүндрэлтэй”,
- “хөдөөгийн багш нарын ур чадвар дунд зэрэг”,
- “БСУГ-ын салбар яамнаас арга зүй, сургалтаар тогтмол хангадаггүй”,
- “сургалтын орчин, хэрэглэгдэхүүний хүрэлцээ хүртээмж чанар, анги танхимын багтаамж хангалтгүй”
- Малчид отор нүүдлээр их явдагаас шилжилт хөдөлгөөн их байдаг.

Гэвч сургуулийн хэмжээнд сургалтын чанарт сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгааг нэгтгэн гаргаж тус сөрөг хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан байхгүй байна.

Боловсролын үнэлгээний төвөөс жил бүр авч байгаа чанарын үнэлгээний судалгаа нь “үндэсний хэмжээнд хэрэгжиж буй хөтөлбөрийн хэрэгжилт, чанар үр дүнг хэмжин үнэлэх, сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тодорхойлох, сургалтын хөтөлбөрийн үр өгөөж, алдаа оноог нягтлан үзэх” зорилготой байгаа ч бүх ЕБС-уудыг бүрэн хамруулж чаддаггүй, үнэлгээний дүнд үндэслэн сургалтын чанарт нөлөөлж буй гол хүчин зүйлсийг тодорхойлж, түүнийг бууруулах талаар холбогдох боловсролын байгууллага, ЕБС-уудад мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллахгүй байна.

аймгийн хэмжээнд нийт 298 багш, ажилчид оролцсон ба “Сургуулийн хэмжээнд сургалтын чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, үнэлэх ажил хийгддэг үү?” гэсэн асуултад оролцогсодын дийлэнх нь буюу 154 оролцогч “тийм”, 29 хувь буюу 87 оролцогч “Тодорхой хэмжээнд хийгдэж эхэлсэн” гэж хариулжээ.

Тус судалгаанд оролцогчдоос

Дүрслэл №13. Санал асуулгын дүн



Аудитын илрүүлэлт:

- БҮТ сургалтын чанарын үнэлгээний судалгааг түүврийн аргаар зохион байгуулахдаа аймгаас 3 сургуулийн 3 ангийн сурагчдаас шалгалт авч байгаа нь аймгийн хэмжээний сурлагын чанар амжилтын ахиц бууралтыг бүрэн төлөөлж чадахгүй байна.
- БҮТ-ийн чанарын үнэлгээний тайланд сурлагын чанарт сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг эцэг эх, сурагчдаас түүврээр санал асуулга авсан байгаа ч тус асуулгын дүнг нэгтгэн аймаг, сургуулийн сурагчдын чанарт сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодорхойлж дүн шинжилгээ хийсэн эсэх нь тодорхойгүй байна.

Иймд цаашид Боловсролын үнэлгээний төвөөс авч байгаа чанарын үнэлгээний судалгааг улсын хэмжээнд өргөн цар хүрээтэй явуулж сургалтын чанарт сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бодитой тогтоож, тус нөлөөллийг бууруулах арга зүйн зөвлөмж боловсруулж үндэсний хэмжээнд мөрдүүлж ажиллах зөвлөмжийг Боловсролын үнэлгээний төвд хүргүүлэх саналыг ҮАГ-т уламжилж байна.

Б.2. Мэргэжлийн хяналтын газраас ерөнхий боловсролын сургуулиудад хийсэн хяналт шалгалтаар сургалтын орчны талаар илрүүлсэн зөрчил дутагдал нь арилахгүй удаа дараа давтагдсаар байгаа нь хөрөнгө санхүүгийн байдлаас хамаарч байна

Б.2.1.1. Аудитад хамрагдсан онуудад яамнаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Б.2.1.2. Аудитад хамрагдсан онуудад Баянхонгор аймгийн ЕБС-ууд Дэлхийн банкны санхүүжилтээр Боловсролын чанарын шинэчлэл төсөл”ийн хүрээнд нийт 573.4 сая төгрөгийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн байна. Тус төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд БСШУЯ-наас түүврээр зарим сургуулиудад хяналт үнэлгээ хийсэн гэх боловч холбогдох баримт байхгүй, аймгийн БСУГ-аас явцын болон үе шатны хяналт үнэлгээг жил бүр хийж байгаа гэх боловч ирүүлсэн баримтаас үзэхэд төслийн хэрэгжилтийг үнэлж үр дүнг тооцоогүй байна.

Хүснэгт №30. ЕБС-уудад хэрэгжүүлсэн тэтгэлэгт төсөл, хөтөлбөр

Сургууль					Сургууль				
	2016-2017	2017-2018	2019 он	Нийт		2016-2017	2017-2018	2019 он	Нийт
Баацагаан	-	7.3	56.3	63.6	Жаргалант	5.9	7.3	-	13.2
Баянбулаг	-	6.9	26.0	33.0	Жаргалант	-	-	26.2	26.2
Баянговь	6.0	-	-	6.0	Заг	6.0	5.0	26.1	37.1
Баянлиг	6.0	7.3	10.2	23.5	Мандалын бага сургууль	-	5.0	-	5.0
Баянлигийн бага сургууль	4.0	3.8	-	7.8	Номгон	6.0	7.0	-	13.0
Баян-Овоо	4.0	-	-	4.0	Номундалай	6.0	6.9	34.3	47.2
Баян-өндөр	-	7.3	-	7.3	Өлзийт	6.0	7.3	-	13.2
Баянцагаан	6.0	7.3	-	13.3	Соогоо сейко	-	7.4	11.0	18.4
Богд	6.1	7.3	36.9	50.3	Хүрээмарал	6.0	6.6	-	12.6
Бөмбөгөр	-	7.3	-	7.3	Шаргалжуут	4.0	4.9	-	8.9
Бууцагаан	6.0	7.3	13.2	26.5	Шинэжинст	-	7.2	11.2	18.4
Бууцагаан бүрдний бага сургууль	3.8	-	-	3.8	Эрдэм	-	6.6	-	6.6
Галуут	5.2	-	26.0	31.2	Эрдэнэмандал	6.1	6.7	11.0	23.7
Гурванбулаг	6.2	7.3	13.0	26.5	Эрдэнэцогт	6.1	7.0	12.7	25.8
НИЙТ ДҮН						105.4	154.0	314.0	573.4

Иймд аймгийн хэмжээний ЕБС-уудад хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийж хэрэгжилтийг тайлагнах албан шаардлагыг аймгийн БСУГ-т хүргүүлэв.

Б.2.1.3. БСУГ-аас ерөнхий боловсролын сургуулиудад жил бүр хяналт шалгалт болон зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгаа ч тухайн үед нь “Тус байгууллагад дүнгийн хурал хийж тайланг тавьдаг байсан” гэсэн тайлбарыг ерөнхий боловсролын сургуулиудын зүгээс өгч байгаа хэдий ч тус сургуулиудад тухайн хяналт шалгалт

хийсэн тухай дүгнэлт тайлан, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах ямар арга хэмжээ авсан нотолгоо баримт материал байхгүй байгаа зэргээс харахад БСУГ-ын хяналтын үр дүнг тооцон ажиллаагүйгээс үр нөлөө гараагүй байна.

Иймд ЕБС-уудад хяналт шалгалт, зөвлөн туслах үйл ажиллагаа явуулахдаа өгсөн арга зүйн зөвлөгөөг баримтжуулж биелэлтийг тооцон хяналт шалгалтын үр нөлөөг тооцож ажиллах зөвлөмжийг аймгийн БСУГ-т хүргүүлэв.

Б.2.1.4. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-д заасны дагуу ерөнхий боловсролын сургуулиуд нь захирлын тушаалаар дотоод хяналт шалгалтын комиссыг томилон хяналт шалгалтын төлөвлөгөө гарган биелэлт, үр дүнг тооцон ажиллаж байна.

ЕБС-ууд нь дотоод хяналтыг үдийн цай, хүүхэд хамгаалал, сурагчдын ирц хичээл таслалт, анги танхимын эрүүл ахуй, орчны аюулгүй байдал, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт зэрэг чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөгөө боловсруулан биелэлтийг гарган шалгалтын дүн түүний дагуу зохион байгуулсан ажил, авсан арга хэмжээний талаар захирлын дэргэдэх зөвлөлд тайлагнаж ажиллаж байгаа боловч зарим сургуулиудын хувьд дотоод хяналтын хэрэгжилт хангалтгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- *Жаргалант бүрэн дунд сургууль 2017 онд сургуулийн үйл ажиллагаанд хийгдэх, дотоод хяналт үнэлгээний нэгдсэн график төлөвлөгөө гарган хяналт шалгалт хэрэгжүүлсэн боловч аудитад хамрагдсан бусад онуудад хийсэн хяналт шалгалтын баримт байхгүй,*
- *Жинст сумын дунд сургууль Дотоод хяналтын хэсэг, комисс байгуулсан тушаал гаргасан боловч 2017-2018 оны төлөвлөгөөнөөс өөр төлөвлөгөө гаргаагүй биелэлтийг тооцож ажиллаагүй,*
- *Хүрээмарал, Бууцагаан сумын дунд сургууль боловсролын үйлчилгээний чанарт дотоод хяналт хийгдээгүй,*
- *Шаргалжуут тосгоны дунд сургууль жил бүр хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулан хяналт шалгалт хэрэгжүүлсэн боловч төлөвлөгөөний биелэлтийг гаргаж үр дүнг тооцоогүй,*
- *Баянлиг сумын Гашуун дэл багийн бага сургууль, Баян-Овоо сумын дунд сургууль дотоод хяналтын нэгж томилсон боловч тухай үед ажиллаж байсан багш нар солигдсон гэх шалтгаанаар дотоод хяналт хийгдэж байгаа тухай баримт нотолгоо байхгүй,*
- *Номундалай сургуулийн дотоод хяналтын нэгж өмнө нь томилсон боловч тухай үед ажиллаж байсан багш нар солигдсон байна. Сургуулийн дотоод хяналтын комиссыг 2019 оны 11 дугаар сарын 29-ны өдрийн А/154 тоот тушаалаар шинэчлэн батласан байсан бөгөөд. 2017-2019 онуудад тус комисс нь хэрхэн яаж ажиллаж байсан талаар нотлох баримт бичиг байхгүй байна.*

Иймд цаашид БШУ-ы сайдын 2013 оны А/315 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэлийн Боловсролын газрын үлгэрчилсэн журам”-ын 2.4.6¹⁷-д заасны дагуу ЕБС-ийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг төлөвшүүлж хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн арга зүйгээр хангаж хэрэгжилтийг тооцож ажиллах зөвлөмжийг аймгийн БСУГ-т хүргүүлэв.

¹⁷ Сургууль, цэцэрлэг, багшийн үйл ажиллагаанд өөрийн үнэлгээ, дотоод хяналт-шинжилгээний тогтолцоо төлөвшүүлэх ажлыг арга зүйн удирдамжаар хангаж зөвлөн туслах, хамтран ажиллах;

Б.2.1.5. Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.8¹⁸ -д заасны дагуу Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сургалтын хөтөлбөрийн чанарт үнэлгээ хийх, дүгнэлт гаргах үүрэгтэй байна.

БСШУС-ын сайдын 2018 А/549 дүгээр тушаалаар “Ерөнхий боловсролы сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал”-ыг баталсан ба тус аргачлалд “Боловсролын шинэчлэлийн болон сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах үйл явц тодорхойгүй, гэнэтийн шинжтэй өөрчлөлтийг ойр ойрхон хийж байгаа менежментийн асуудлуудаас болоод үр дүнтэйгээр боловсролын чанарыг сайжруулах, сургалтын хөтөлбөрийн урт, дунд хугацааны хэрэгжилтийн үр дүнд дүгнэлт хийх боломж бүрдэхгүй” байгааг дурьдсан, мөн аудитад хамрагдсан онуудад салбарын яамнаас сургалтын цөм хөтөлбөрийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа үйл явцад хяналт үнэлгээ хийсэн тухай баримт байхгүй байна.

Б.2.1.6. Баянхонгор аймагт багш бэлтгэдэг их дээд сургууль байхгүй.

Б.2.1.7. Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд сургалтын хөтөлбөрт хяналт хэрэгжүүлэхдээ багш нар яамнаас баталсан цөм хөтөлбөрийн агуулгын хүрээнд сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж заах аргын нэгдлээр хэлэлцүүлж сургалтын менежерээр батлуулан сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна.

Багш сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу хичээлийн бэлтгэл ханган орж байгаа эсэхэд сургуулийн захирал, менежерүүд багш нарын хичээлд тодорхой давтамжтайгаар суух, нэгж сэдэвтэй холбоотой сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэл хангалтыг бүртгэл хөтлөн хянах зэргээр анхан шатны хяналтыг хэрэгжүүлж байна.

ЕБС-ууд нь хөтөлбөрийн хэрэгжилтийг дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусган хяналт тавьж үр дүнг захирлын зөвлөлөөр хэлэлцүүлэн илэрсэн зөрчил дутагдлыг дахин давтан гаргахгүй байх хэрхэн зөрчлөө арилгах талаар заавар зөвлөгөө өгч хугацаатай албан даалгавар өгч ажиллаж байна.

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд БСУГ-аас жилд 2 удаа хяналт хийж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлдэг гэх бөгөөд энэ талаар нотлох баримт материал ЕБС-иудад байхгүй байна. Үүнээс үзэхэд БСУГ-ын мэргэжилтнүүд хяналт хийж, зөвлөн туслахдаа баримтжуулдаггүй, тухайн үед нь амаар зөвөлгөө өгч биелэлтийг тооцдоггүйгээс зөвлөх туслах үйл ажиллагааны үр дүн гараагүй байна.

Иймд ЕБС-уудад хяналт шалгалт, зөвлөн туслах үйл ажиллагаа явуулахдаа өгсөн арга зүйн зөвөлгөөг баримтжуулж биелэлтийг гаргаж хяналт шалгалтын үр нөлөөг тооцож ажиллах зөвлөмжийг аймгийн БСУГ-т хүргүүлэв.

¹⁸ Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь боловсролын хөтөлбөр, норм, нормативыг хэрхэн хэрэгжүүлж байгааг тогтоох зорилгоор боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн чанарт үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, хүүхдийн хөгжлийн ахиц дэвшлийг дэмжих, баталгаажуулах чиглэлээр мэргэжлийн удирдлагаар хангах

Б.2.2.1. Аймгийн МХГ нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх шалгалт, тандалт судалгаа гэсэн чиглэлээр хяналт шалгалтыг ЕБС-уудад хийж гарсан алдаа зөрчилд албан шаалдлага хүргүүлэн хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан байна.

МХГ-аас 2018 онд ерөнхий боловсролын сургуулиудыг 100 хувь бүрэн хамруулан төлөвлөгөөт шалгалтыг хийсэн бөгөөд шалгалтын дүнд өмнөх онуудад боловсролын хяналтын чиглэлээр хийгдсэн шалгалтаар илэрсэн зөрчлийн 35% нь арилахгүй байсаар гэж тайлагнасан байна.



Доорх зөрчил арилгахад төсөв санхүү, барилга байгууламжийн хуучирч муудсан, зориулалтын бус, мэргэжлийн боловсон хүчний хөдөө ажиллах орчин нөхцөл муу зэргээс шалтгаалан давтан гарсаар байна гэж дүгнэжээ. Үүнд:

- ЕБС-ын биеийн тамирын талбайн тоног төхөөрөмж хэрэглэгдэхүүн нь стандарт хүүхдийн насанд тохирсон иж бүрдлээр бүрэн хангагдаагүй, хими, физик, гадаад хэл, технологийн хичээлүүдийн дадлага хийх зориулалтын лаборатори, кабинет байхгүй, лабораторийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж нь дадлага хийхэд хүрэлцдэггүй химийн хичээлд ашиглах урвалж бодис дутмаг, хадгалалт хамгаалалт аюулгүй байдлыг хангахгүй сурагчийн сурч боловсрох эрх зөрчигдөж сургалтын чанарт төдийлөн ахиц гараагүй;
- Мөн 2017 онд бүх шатны боловсролын байгууллагад багшлах боловсон хүчний хангамж чанарт тандалт судалгаа хийсэн дүнгээс харахад сумын ЕБС нь мэргэжлийн багшаар бүрэн хангагдаагүй;
- Аймгийн төвийн ЕБС-ийн 1 дүгээр ангийн 84 хувь нь анги дүүргэлтийн дундаж 40 ба түүнээс дээш, хүчин чадлаасаа 2 дахин их сурагчтай, зарим сургуулийн 1 дүгээр ангид байгаа хүүхдийн тоо нормативаасаа 1.4 дахин их;
- Аймгийн хэмжээнд 22 дотуур байр үйл ажиллагаагаа явуулж байгаагаас 18 хувь нь зориулалтын бус, сургалт хүмүүжлийн барилга нь хуучирч дээвэр, хана, дулаан, цэвэр, бохир усны сантехник, шугам хоолой, цахилгаан агааржуулалтын систем элэгдэлд орсон засвар үйлчилгээ хангалтгүй;
- Ариун цэврийн нэг тоноглолд ноогдох хүүхдийн тоо 2-3 дахин их, сургуулийн үдийн цай өгч байгаа гал тогооны газрын 61.6 хувь нь зориулалтын бус, технологийн урсгал буруу, халуун боловсруулалт угаалгын өрөө нэг дор байрладаг, дотуур байрны 73.1 хувь нь эрүүл ахуйн нөхцөл хангалтгүй зэрэг зөрчлүүд байна.

Дээрх зөрчлүүд барагдаагүйгээс холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцсон эсэх талаар МХГ-ын боловсролын хяналтын улсын байцаагчаас тодруулахад албан шаардлага болон албан бичгийг удаа дараа хүргүүлснээс өөр хариуцлагын арга хэмжээ аваагүй байна.

Мэргэжлийн хяналтын газраас ерөнхий боловсролын сургуулиудад хийсэн хяналт шалгалтаар сургалтын орчны талаар илрүүлсэн / угаалтуур суултуурын тоо хүрэлцээгүй, зарим сургуульд гар угаах нөхцлөөр хангагдаагүй, хими, физикийн лаборатори кабинет, технологийн дадлагын газар, хичээлийн байр дотуур байрны гадаад орчин стандартын шаардлагыг бүрэн хангаагүй/ зөрчил дутагдал нь арилахгүй удаа дараа давтагдсаар байна. Шалгалтаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг

хэрэгжүүлэхээр сургуулийн удирдлагууд хуулиар хүлээсэн эрх үүргийн хүрээнд холбогдох арга хэмжээг авдаг боловч хөрөнгө санхүүгийн байдлаас шалтгаалан зохих үр дүнд хүрэхгүй байна.

Б.2.2.2. Сургуулийг нээлттэй, чанартай, хүртээмжтэй боловсролын үйлчилгээ үзүүлэх, сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх, олон нийт бусад талуудын оролцоог нэмэгдүүлэн хөндлөнгийн хяналт, хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор “Тэгш хамруулсан- Олон нийтийн оролцоот сургууль” төслийг 2017-2018 оны хичээлийн жилээс аймгийн төвийн “Эрдэм” ахлах сургууль, Заг сумын 9 жилийн сургууль дээр эхлэн хэрэгжүүлж ажилласан бол 2018-2019 оны хичээлийн жилээс аймгийн төвийн “Номгон” ахлах сургууль, Галуут сумын ЕБС-ийг нэмж хамруулан төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Тус төслийг хэрэгжүүлснээр хүүхэд бүрт хүрч үйлчлэх арга замыг тухайн төсөл хэрэгжүүлэгч сургуулиуд өөрийн орон нутгийн онцлогт тохируулан тодорхойлж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үе тэнгийнхэнтэйгээ хамт суралцах боломж, эцэг эх олон нийтийн оролцоо, хяналт, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа нэмэгдэж төслийн үр дүн гарсан тухай аймгийн БСУГ-ын хичээлээс гадуурах үйл ажиллагаа, хүүхэд хамгааллын бодлого хариуцсан мэргэжилтний тус төслийн хэрэгжилтэд хийсэн тайланд дурдсан байгаа ч хэдэн хүүхдэд ямар үр дүн гарсныг тоон болон чанарын үзүүлэлтээр тооцоогүй байгаа нь тус төслийн үр дүн гараагүй гэж үзэхээр байна.

Харин бусад ЕБС-иудын хувьд эцэг эхийн зөвлөлтэй хамтран сургалт, зөвөлгөөн, эцэг эхийн нэг өдөр, спорт өдөрлөг зэрэг үйл ажиллагааг зохион байгуулдаг ба эцэг эхийн зөвлөл, эцэг эхчүүдээс сургуулийн үдийн цайны чанар, сургуулийн орчны үнэлгээг хийх зэргээр хяналт хэрэгжүүлж байгаа ч тодорхой цаг хугацааны давтамжгүй, хэрэгжилтийг тооцох боломжгүй байгаа нь эцэг эх, олон нийтийн зүгээс тавих хяналт үүрэг оролцоо хангалтгүй, үр дүнг тооцох боломжгүй байна.

Иймд цаашид БШУ-ы сайдын 2013 оны А/315 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэлийн Боловсролын газрын үлгэрчилсэн журам”-ын 2.4.4¹⁹-д заасны дагуу сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх, олон нийтийн зүгээс тавих хяналт, оролцоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг нь идэвхижүүлэхэд нэгдсэн арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулж ажиллах зөвлөмжийг аймгийн БСУГ-т хүргүүлэв.

Аудитаар нийт 378.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж 21.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож 8.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 348.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүлэв.

¹⁹ Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны чанар, үр дүнг үнэлэх, хяналт-шинжилгээ хийх ажлыг олон нийт, иргэний нийгмийн байгууллагын оролцоотой зохион байгуулах, зөвлөн туслах;

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай холбоотой Аймгийн ЗДТГ болон СТСХ нь саналгүй гэсэн хариу өгсөн бол аймгийн БСУГ-ын 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 255 тоот албан бичиг, аймгийн МХГ-ын 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 02/432 тоот албан бичгээр дараах саналуудыг ирүүлсэн байна

№	Ирүүлсэн санал
АЙМГИЙН БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГИЙН ГАЗАР	
1	А.2.1.3. хэсэгт сургуулиудын ээлжийн коэффициент-ийг бууруулах арга хэмжээ авах зайлшгүй шаардлага байна. Сургалтын байгууллагын ачаалал ихэссэнээс болж сургуулиуд анги танхим, өрөө тасалгааны хүрэлцээгүйгээс хичээлийн байрныхаа коридор, фестивулийг анги танхим, өрөө тасалгаа болгон зориулалтыг нь өөрчилдөг
2	А.2.3.2. Сайн багш хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээний хэсгийн 1 дэх хэсэгт Дидактик, сэтгэл судлал, менежментийн онолын мэдлэгийг сэргээх хөтөлбөр модуль боловсруулж бүх багш нарт сургалтыг явуулсан. Багшийн мэргэшлийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг жил бүр явуулсан. Сургалтын үйл ажиллагааг контекстэд суурилж явуулдаг болохын тулд аялал экскурсийг 4 жил хийж 400 гаруй багшийг хамарсан байна.
3	2 дахь хэсэгт Багш сайн ажиллах, өөрийг хөгжүүлэхэд нь төр захиргааны байгууллагын “дэмжлэг ба туслалцаа” баримт бичгийг аймгийн Засаг даргын захирамжаар батлуулснаар аймаг, сумын Засаг дарга БСУГ, сургуулийн захирал тус бүрийн үзүүлэх дэмжлэг туслалцаа тодорхой болсон.
4	3 дахь хэсэгт Сайн багш шалгуур /3 шалгуур 9 үзүүлэлттэй/, “Сайн багш”-ийг тодруулах үйл ажиллагааны аргачлал” баримт бичгүүдийг боловсруулж аймгийн засаг даргын захирамжаар батлуулсан, “сургууль цэцэрлэг, бүс, аймгийн сайн багш нарт олгох урамшуулал, үзүүлэх дэмжлэг” баримт бичгийг боловсруулсан, аймгийн засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлсэн, “сайн багш тодруулах аргачлалыг зөв хэрэгжүүлэх чиглүүлэг, зөвлөмж” баримт бичгүүд гарсан байна.
5	А.2.3.2.-ийн дүгнэлтийн хэсэгтээ БСУГ зарцуулах зардлын хувьд: 2018 онд 10 сая гэж баталснаас “дидактикийн онолын мэдлэгийг сэргээх сургалт”-д л 4.0 сая гаруйг нь бусдыг нь багш нараас шалгалт авах зардалд, 2019 онд хөтөлбөр хэрэгжүүлэхэд батлагдсан төсөв “Залуу багш нарын аймгийн анхдугаар чуулган” явуулахад зарцуулсан, 2020 онд 10 сая төгрөг төлөвлөснийг бүрэн зарцуулна. Сургууль цэцэрлэгүүд хөтөлбөр хэрэгжүүлэх зардалд гэж аймгийн ИТХ-аас төсөвт нь зардалд тусгадаг боловч уул уурхайгаас аймгийн төсөвт орсон орлогоос хуваарилж байсан эсэхийг тодруулах шаардлагатай.
6	Дараах чиглэлээр аудитын шинжилгээ хийлгэх саналтай байна. -Боловсролын бүх түвшний удирдлагын мэргэших, тогтвортой ажиллахтай холбогдох мэдээлэл, боловсролын салбарт улс төрийн оролцоо хир нөлөөлж байгаа дүгнэлт -Боловсролын байгууллага, ажилтны эрх, үүргийн хэрэгжилт, эрх чөлөөний асуудлыг авч үзэх.
АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР	
1	Тайлангийн дүгнэлт хэсэгт МХГ-ын талаар хийсэн дүгнэлт хэт ерөнхийлсөн байна. Сургалтын орчны талаарх дутагдал арилахгүй, хэрэгжихгүй талаар дурдах.

САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

Ирүүлсэн санал, баримт материалд үндэслэн дараах тайлбарыг өгч байна.

№	Санал	Саналд өгсөн тайлбар
АЙМГИЙН БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГИЙН ГАЗАР		
1	Санал 1.	Тус саналыг хүлээн авч тайланд тусгав
2	Санал 2.	Тус саналыг хүлээн авч тайланд тусгав
3	Санал 3.	Тус саналыг хүлээн авч тайланд тусгав
4	Санал 4.	Тус саналыг хүлээн авч тайланд тусгав
5	Санал 5.	Тайлангийн А.3.2.3 хэсэгт тус асуудлыг тусгасан байгаа болно.
6	Санал 6.	Тус асуудлуудыг ҮАГ-т хүргүүлэх.
АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР		
1	Санал-1.	МХГ-аас хяналт шалгалт явуулж, албан шаардлага хүргүүлж байгаа болон хэрэгжихэд төсөв санхүү, хөрөнгө шаардлагатай болдоггүй хэрэгжихгүй байгаа талаар тайланд дурдсан болно.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Аймгийн хэмжээнд 2016-2019 оны хичээлийн жилүүдэд 870-887 багш, 15713-16109 хүүхдэд ерөнхий боловсрол олгож төсвөөс 21044.2 -26889.1 сая төгрөгийг зарцуулжээ.
2. Баянхонгор аймгийн хэмжээнд 2019 оны статистик мэдээгээр бага дунд боловсролын нийт хамрагдалт 81,9 хувьтай байгаа бөгөөд сургалтын үйл ажиллагааг төрийн өмчийн 29, хувийн өмчийн 1 сургуулийн 606 бүлэгт 16109 хүүхэд хичээллэн, бүлэг дүүргэлт дунджаар 27 хүүхэдтэй хичээллэж байгаа ч зарим сургууль 51 хүртэл бүлэг дүүргэлт хийж анги дүүргэлтийн нормыг хэтрүүлсэн байна.
3. Боловсролын салбарт мөрдөгдөж буй зарим эрхзүйн зохицуулалт хоорондын зөрчилдөөнтэй, өнөөгийн нөхцөл байдалд нийцэж шинэчлэгдээгүй байна.
4. Байгууллагын удирдлага, менежер, ХАБ-ын ажилтан сургуулийн гадаад болон дотоод орчны аюулгүй байдалд материаллаг талаас нь анхаарч, аюул, ослоос сэргийлэх, анхны тусламж үзүүлэх, мэдлэг олгох талыг орхигдуулсан байна.
5. Орон нутгийн түвшинд хүний нөөц, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг урьдчилан тооцдоггүй, төсвийн болон хөрөнгө оруулалтын зөв хуваарилалт хийж тэгш хүртээмжтэй орчин бүрдүүлээгүйгээс зарим сургуулийн багшийн ачаалал их, мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдаагүй байна.
6. Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг Засгийн газар зах зээлийн үнийн өсөлттэй уялдуулан шинэчлэн тогтоогоогүйгээс хувьсах зардлын норм нь өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй зөрчигдөх нөхцөл байдал үүссэн төлөвлөлтийг хувьсах зардлын нормативаар тооцож байгаа ч гүйцэтгэлийг гаргахдаа хувьсах зардлын нормативыг баримтлахгүй эдийн засгийн ангиллаар тайлагнаж байна.
7. Бүх нийтийн ерөнхий боловсролын үйл ажиллагааны санхүүжилтийг оновчтой хуваарилж, хяналтыг бүрэн хэрэгжүүлдэггүйгээс зардлын хэмнэлтийг төсвийн зохицуулалтаар бусад зардалд дахин хуваарилж зарцуулдаг жишиг тогтсон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх заалттай нийцэхгүй байна.
8. Ерөнхий боловсрол олгох үйлчилгээний үр дүнд салбарын яамнаас хийж буй чанарын үнэлгээг хязгаарлагдмал хүрээнд хийснээс сургалтын чанар бодитой үнэлэгдэхгүй, сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлийг тодорхойлохгүй байна.
9. Баянхонгор аймаг нь Боловсролын үнэлгээний төвийн чанарын үнэлгээгээр 2017, 2018 онуудад улсын дунджаас доогуур үнэлэгдэж байсан бол 2019 онд бага суурь боловсрол нь улсын дунджаас дээгүүр үнэлэгджээ.
10. Боловсрол соёл урлагийн газар нь жил бүр ЕБС-удад үнэлгээ хийж, арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллаж байгаа хэдий ч биелэлтийг тооцоогүй байгаа нь зохион байгуулсан ажлын үр дүнг тооцох боломжгүй байна.
11. Аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд тавих хяналт шалгалтыг бүрэн хэрэгжүүлээгүй, хяналт шалгалтын үр дүнг тооцож ажиллахгүй байна.
12. Аймгийн төвийн “Номундалай”, “Номгон”, “Эрдэнэмандал”, “Эрдэм” ахлах сургуулиудад нийлүүлэгдсэн 32.9 сая төгрөгийн шүдний тоног төхөөрөмж мэргэжлийн эмчийн орон тоо байхгүйгээс ашиглалтгүй байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ИТХ-ЫН ДАРГА Э.ЭНХБАТ ТАНАА:

1. Аймгийн ИТХ-ын хуралдааны 2018 оны 14/01 тоот тогтоолоор баталсан “Баянхонгор аймгийн боловсролын салбарыг 2020-2030 онд хөгжүүлэх дунд хугацааны бодлогын баримт бичиг”-ийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, үр дүнг тооцож хуулиар тодорхойлсон чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах.

ХОЁР. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА:

1. Баянхонгор аймгийн боловсролын салбарыг 2020-2030 онд хөгжүүлэх дунд хугацааны бодлогын баримт бичиг”-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөц, төсөв санхүүгийн тооцоо, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах
2. Боловсролын салбарт хийгдэх хөрөнгө оруулалтын үр ашиг, өнөөгийн нөхцөл байдлыг оновчтой тооцож, хэрэгцээ шаардлагын эрэмбийг тогтоон төлөвлөлтийг бодитой хийж байх.
3. Орон нутгаас боловсролын талаар баримталж байгаа бодлого, дэд хөтөлбөрүүдийн биелэлтийг үнэн зөв гарган аймгийн ИТХ-д тайлагнах, Нийгмийн бодлогын хэлтсийн ажлын хариуцлагыг сайжруулах.

ГУРАВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗДТГ-ЫН СТСХ-ИЙН ДАРГА С.БАЙГАЛМАА ТАНАА:

1. ЕБС-ууд төсвийн төслийг холбогдох, заавар аргачлалын дагуу үнэн зөв төлөвлөж байгаад хяналт тавьж, төсвийн төслийн нэгтгэл, батлагдсан төсөвт орсон өөрчлөлт бүрийг нэгтгэн боловсруулж Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7 дахь заалтыг мөрдөж ажиллах.
2. ЕБС-удын санхүүжилтийг БСШУСС, НХХС, СС-ын 2007 оны 307/91/237 тоот хамтарсан тушаалаар баталсан журмаар тогтоосон тоон үзүүлэлт, норм нормативыг харгалзан үзэж оновчтой хуваарилан, санхүүжилтийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, төрийн бус өмчийн боловсролын байгууллагын хувьсах зардлын санхүүжилтийг хүүхэд өдрийн гүйцэтгэлээр тооцон олгож, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх.

ДӨРӨВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН БСУГ-ЫН ДАРГА М.МӨНХБАТ ТАНАА:

1. ЕБС-удын анги, бүлэг зохион байгуулалтад хяналт тавьж зохих түвшинд барьж бодлого арга зүйгээр хангаж ажиллах.
2. Орчны нарийвчилсан үнэлгээ хийж 6 настай хүүхдийн бие бялдрын хөгжилд тохирсон ширээ, сандал болон физик, хими, биологи, технологийн хичээлүүдийн материаллаг орчныг бүрдүүлэх төсвийн тооцоог хийж байгууллагын төсвийн төсөлд тусгаж, эрх бүхий байгууллагад хүргүүлж байх.
3. Сургуулийн гадаад болон дотоод орчинд тулгарч болох эрсдэлийн жагсаалт гарган холбогдох мэргэжлийн байгууллагаас багш, сурагч, ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулж, мэдээллийн сан үүсгэх ажлыг зохион байгуулах, эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гарсан сургуулиудын эрсдэлийг бууруулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллан биелэлтийг тооцож ирүүлэх.
4. Мэргэжлийн бус багш нарыг хөрвөх сургалтад хамруулах, мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангах арга хэмжээг зохион байгуулж ажиллах

5. Аймгийн хэмжээний багш нарын эрэлт хэрэгцээний судалгааг сум, байршил, мэргэжил тус бүрээр гаргаж нэгдсэн сан үүсгэн, дээд шатны шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад санал дэвшүүлэн ажиллах.
6. ЕБС-ийн захирал, сургалтын менежер нараас багшийн төлөвлөгөө хөтөлбөр, хичээлийн бэлтгэл хангалтад тавих хяналтыг сайжруулж, үр дүнг тогтмол үнэлж хэвшүүлэхэд нэгдсэн арга зүйн удирдлагаар хангаж ажиллах.
7. Сурлагын чанар амжилтын тогтмол сайн үзүүлэлт гаргаж байгаа сургуулиудын сайн туршлагыг бусад сургуулиудад түгээх, туршлага солилцуулах үйл ажиллагааг идэвхжүүлж аймгийн хэмжээний сурлагын чанар амжилтын түвшнийг нэмэгдүүлэхэд нэгдсэн бодлого арга зүй, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах.
8. БШУ-ны сайдын 2013 оны А/315 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэлийн Боловсролын газрын үлгэрчилсэн журам”-ын 2.4.4, 2.4.6 –д заалтын дагуу сургуулийн дотоод хяналт, эцэг эх, олон нийтийн зүгээс тавих хяналт, оролцоог нэмэгдүүлж, үйл ажиллагааг сайжруулан нэгдсэн арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулж ажиллах.
9. БШУ-ы сайдын 2013 оны А/315 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэлийн Боловсролын газрын үлгэрчилсэн журам”-ын 2.1.1-д заасны дагуу ЕБС-ууд хүүхдийн цүнхий жингийн талаар БСШУСЯ-аас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах
10. ЕБС-уудад хяналт шалгалт, зөвлөн туслах үйл ажиллагаа явуулахдаа өгсөн арга зүйн зөвлөгөөг баримтжуулж биелэлтийг тооцон хяналт шалгалтын үр нөлөөг тооцож ажиллах.

ТАВ. АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ДАРГА Ц.ИДЭРМӨНХ ТАНАА:

1. Аймгийн төвийн “Номундалай”, “Номгон”, “Эрдэнэмандал”, “Эрдэм” ахлах сургуулиудад нийлүүлэгдсэн шүдний тоног төхөөрөмжийг цаашид хэрхэн ашиглах талаар шийдвэр гаргаж, төсвийн хөрөнгийн үр ашгийг гаргах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 09 дүгээр сарын 15-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

ҮАГ-ЫН ГАГ-Т ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:

1. Боловсролын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 28 дугаар зүйлийн 28.1.23, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.4 дэх заалтуудад заасан дүрэм, журмыг баталж нийтэд мэдээлэх, мөн Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно” гэж заасан байхад хувьсах зардлын норматив нь 2016 оноос хойш шинэчлэн батлаагүй байгаа нь Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь заалттай нийцэхгүй байгаа тул тус хуулийн зөрчилдөөнтэй болон шинэчлэх шаардлагатай заалтуудыг өөрчлөх зөвлөмжийг эрх бүхий байгууллагад хүргүүлэх.
2. БСШУС-ын сайд, Сангийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/024/11 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар “Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив”-д хоол зүйчийн орон тоо байхгүй байгаа нь Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 6.5 дахь заалттай нийцэхгүй байгаа тул орон тооны жишиг нормативыг өөрчлөх саналыг эрх бүхий байгууллагад, Хуульд заасан шаардлагатай орон тоог ЕБС-уудад баталж төсөвт тусгах саналыг Сангийн яаманд хүргүүлэх. /ЕБС-уудад хоол зүйчийн болон сэтгэл зүйчийн орон тоо чухал хэрэгцээтэй байна./
3. Боловсролын төсвийн хяналтыг сайжруулах зорилгоор төсвийн мэргэжилтнийг аймгийн БСУГ-т шилжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх зөвлөмжийг БСШУЯ-д хүргүүлэх.
4. ЕБС бүрд бүх мэргэжлийн багшийг зайлшгүй байлгах зорилгоор хамран суралцагсдыг сайжруулах, сумдын сургуулийн багшийн цагийн нормативыг тусгайлан онцлогт тохируулж тогтоох зөвлөмжийг БСШУЯ болон бусад холбогдох шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад хүргэх.
5. Боловсролын үнэлгээний төвөөс авч байгаа чанарын үнэлгээний судалгааг улсын хэмжээнд өргөн цар хүрээтэй явуулж сургалтын чанарт сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бодитой тогтоож, тус нөлөөллийг бууруулах арга зүйн зөвлөмж боловсруулж үндэсний хэмжээнд мөрдүүлж ажиллах зөвлөмжийг БҮТ-д хүргүүлэх.
6. Сумдын бага сургуулиудад суралцаж байгаа хүүхдүүдийг сумын төвийн сургуульд нэгтгэх бололцоог судлах зөвлөмжийг БСШУЯ-нд хүргүүлэх

Мөн аймгийн БСУГ-аас доорх 2 саналыг ирүүлснийг уламжилж байна.

1. Боловсролын бүх түвшний удирдлагын мэргэших, тогтвортой ажиллахтай холбогдох мэдээлэл, боловсролын салбарт улс төрийн оролцоо хир нөлөөлж байгаа дүгнэлт гаргах.
2. Боловсролын байгууллага, ажилтны эрх, үүргийн хэрэгжилт, эрх чөлөөний асуудлыг авч үзэх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ